



БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



*Empowered lives
Resilient nations*



ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ЭКОСИСТЕМИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ХӨГЖИЛД
ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР БУЮУ ЭДИЙН
ЗАСГИЙН ҮНЭ ЦЭНЭ

2015



БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



*Empowered lives
Resilient nations*

ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР БУЮУ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭ ЦЭНЭ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2015 он

Уг судалгааны ажлыг НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Даян дэлхийн байгаль орчны сангийн дэмжлэгээр хэрэгжүүлж буй “Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд гүйцэтгэв.

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНААС

ТАЛАРХАЛ

Энэхүү тайланг боловсруулахад хамтран ажиллаж, туслалцаа үзүүлсэн төрийн болон хувийн салбарын байгууллагууд, тэр дундаа Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын Хамгаалалтын захиргааны мэргэжилтнүүд, Байгаль Орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын Яам, Үндэсний Статистикийн Хороо, Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яамны хамт олонд талархсанаа илэрхийлж байна.

2013 оны 10-р сараас 2014 оны 9-р сар хүртэлх хугацаанд томилолтоор ажиллах, уулзалт, хурал хийх, тоо мэдээ, материал цуглуулах ажлыг зохион байгуулах, мөн ажлын өрөө, тасалгаа, техникийн болон бусад туслалцаа үзүүлсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт гүнээ талархал илэрхийлье.

ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР БУЮУ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭ ЦЭНЭ

СУДАЛГААНЫ БАГ:

Марлон Флорес

Багийн ахлагч (Байгаль орчны эдийн засагч)
Вашингтон хотын Экологийн Институтын Байгаль орчны
эдийн засаг, санхүүгийн зөвлөх багш
marlon.flores@eius.us

Гончигсумлаагийн Ганзориг

Монгол улсын Хөдөө, Аж Ахуйн Их Сургуулийн Байгаль
Орчны эдийн засагч, үндэсний зөвлөх
ganjaa123@yahoo.com

Сүрэнжавын Хоролмаа

Эдийн засагч, үндэсний зөвлөх
s_khorol@yahoo.com
khorolmaa.surenjav@greenresources.com.au

Эх бэлтгэлийг:

Б.Сарнай

Хэвлэлийн хуудас: 8,75
“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.



АГУУЛГА

ХУРААНГУЙ	5
ОРШИЛ	10
2. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ, ЭКОСИСТЕМ, ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ БА ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР	11
1.2. ГТБЦГ-т учирч буй аюул.....	13
1.3 ГТБЦГ-т тулгарч буй санхүүгийн асуудал.....	13
3. ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БЦГ-ЫН ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМРИЙГ ҮНЭЛЭХ НЬ.....	15
3.1 Судалгааны арга зүй	15
3.2. Байгалийн аялал жуулчлал	17
3.3 Усалгаатай газар тариалан (ургац)	22
3.3 Мал аж ахуй	25
3.5. Ундны ус.....	27
4. ДҮГНЭЛТ, БОДЛОГЫН САНАЛ ЗӨВЛӨМЖ	31
4.1 Дүгнэлт.....	31
4.2.Санал, зөвлөмж	31
Ашигласан эх сурвалж	34

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БАЖ	Байгалийн Аялал Жуулчлал
БББ	Бизнес Байгаагаараа Байх
БКХО	Байгалийн Капиталд Хөрөнгө Оруулах
БОНХАЖЯ	Байгаль Орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын Яам
ГТБЦГ	Горхи-Тэрэлжийн Байгалийн Цогцолборт Газар
ЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ЗСШ	Зорилтот Салбарын Шинжилгээ
ИНБНГ	Их Нарт Байгалийн Нөөц Газар
МУТХГНС	Монгол Улсын Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн Сүлжээ
НҮБХХ	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ОХБЦГ	Орхоны Хөндийн Байгалийн Цогцолборт Газар
ТХГНСБ төсөл	“Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн Сүлжээг Бэхжүүлэх нь” төсөл
ТББ	Төрийн Бус Байгууллага
ТХНУГ	Тусгай Хамгаалалттай Нутгийн Удирдлагын Газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХХААЯ	Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яам
ХХДЦГ	Хан Хэнтийн Дархан Цаазат газар
ЭСҮ	Экосистемийн Үйлчилгээ
НАК	Нүүдэлчин Аяллын Компани
ТГСГУМТ	Туул Голын Сав Газрын Усны Менежментийн Төлөвлөгөө



ХУРААНГУЙ

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр нь Даян дэлхийн байгаль орчны сангийн хамтарсан санхүүжилтээр “Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх нь (ТХГНСБ” (2010-2015) төслийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамтай хамтран хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн үндсэн зорилго нь Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний санхүүгийн тогтвортой байдал, менежментийн үр дүнт байдлыг хангуулахад дэмжлэг үзүүлэхэд оршино. Төслийн хүрээнд ТХГН-ийн санхүүжилт дутмаг байдлыг нөхөж, урт хугацаанд тогтвортой байлгах үүднээс ТХГН-ийн сүлжээний санхүүгийн чадамжийг хөгжүүлэх, ТХГН-ийн удирдлагууд, орон нутгийн хоршоод, нутгийн удирдлага, ТББ-ууд болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, бэхжүүлэхийг зорин ажилласан байна.

Судалгааны зорилгын хүрээнд Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ (ТХГНС)-ний эдийн засагт оруулж буй хувь нэмрийг үнэлж, Горхи Тэрэлжийн БЦГ, Их Нартын БНГ, Орхоны хөндий БЦГ гэсэн гурван газрын дэлгэрэнгүй судалгааг тус тусын тайланд тусгав. Энэхүү тайланд Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрыг авч үзлээ.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжээд удаагүй төв болон зүүн европын орнуудын адил Монгол улсын эдийн засаг уламжлалт салбаруудын үйл ажиллагаан дээр тогтож байгаа билээ. Гэвч энэхүү үйл явц нь Монгол орны байгалийн капитал, ЭСҮ-г доройтуулах шалтгаан болж байна. ТХГН-ийн экосистем нь Монгол улсын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд зайлшгүй шаардлагатай арвин хийгээд үнэгүй үйлчилгээгээр хангадаг. Одоогоор ЭСҮ-г зүй зохисгүй ашигласны сөрөг нөлөө мэдэгдэхүйц нэмэгдэж байна. Монгол улс нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд хүрэхэд энэхүү нөхцөл байдал саад болж байгаа билээ.

ТХГН, экосистем, экосистемийн үйлчилгээ (ЭСҮ)-ний ерөнхий ойлголт, тэдгээр нь хоорондоо хэрхэн холбогддог, ГТБЦГ-ын ерөнхий мэдээлэл,

санхүүгийн тулгамдсан асуудал (ж.нь: ЗГ-аас ГТБЦГ-ыг хамгаалахад шаардлагатай нийт зардлын хорь хүрэхгүй хувийн хөрөнгө оруулалт хийж байна)-ыг 2-р бүлгээс үзнэ үү.

Гуравдугаар бүлэг нь судалгааны гол хэсэг бөгөөд ГТБЦГ-ын ЭСҮ-ний менежментэд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр салбаруудын тогтвортой үр ашиг хийгээд хүн ардын аж амьдралд хэрхэн эерэгээр нөлөөлөх талаар тодорхой баримтыг харуулна. Энэхүү судалгаанд Төв аймаг болон Улаанбаатар хотын эдийн засгийн үйл ажиллагаа болоод ЭСҮ-г судлах зорилт тавин, Төв аймгийн Батсүмбэр, Баяндэлгэр, Эрдэнэ сумд болон Улаанбаатар хотын Баянзүрх, Налайх дүүргийг хамруулав.

Судалгаанд экосистемийн үйлчилгээний үр ашиг, бусад хүчин зүйлс болоод салбаруудын үр өгөөжийн харилцан хамаарлыг үнэлэх зорилгоор Зорилтот Салбарын Шинжилгээ (ЗСШ)¹-ний аргыг ашиглав. ЗСШ-ний арга зүйгээр ТХГН-ийн экосистемийн менежментийн “муу” “сайн” хувилбар буюу “Бизнес Байгаагаараа Байх (БББ) хувилбар”, “Байгалийн Капиталд Хөрөнгө Оруулах (БКХО) хувилбар”²-ыг харьцуулах замаар бодлогын хэмжээний хоёр үндсэн асуултанд

¹ ЗСШ гэдэг нь нэг эсвэл олон салбарыг хамран судалдаг. Тус судалгааг 2013 оны 12-р сард НҮБХХ-ийн ЗСШ-ний албан ёсны арга зүйг батлахаас өмнө төлөвлөн, хөтөлбөрийг нь гаргасан болно.

² Бизнес Байгаагаараа Байх хувилбар (БББ хувилбар) – тусгай хамгаалалттай газар нутагт оруулж буй хөрөнгө оруулалт хангалтгүй хэвээр байх: ТХГН-т оруулж буй хөрөнгө оруулалт, менежментийн өнөөгийн хандлага хийгээд цаашид энэ байдлаар үргэлжилбэл ямар нөхцөл байдал үүсэхийг харуулдаг. Үүний дүнд одоо байгаа болоод цаашид хамгаалалтанд багтах газруудад хөрөнгө оруулалт үгүй болж, менежмент нь улам сулрах юм. Хөрөнгө оруулалт хангалтгүй байгаагаас биологийн төрөл зүйл, экосистемийн менежментийг сайжруулах боломжгүй: Тусгай хамгаалалттай газар нутаг нь экосистемийн нэн чухал үйлчилгээ (тухайлбал: усны нөөц, усны хагалбарыг хамгаалах, үерийн аюулаас хамгаалах)-г үзүүлдэг боловч тэдгээрийн чанар, үр нөлөө өдөр ирэх тусам багассаар байна. **Байгалийн Капиталд Хөрөнгө оруулах хувилбар (БКХО хувилбар)** – Тусгай хамгаалалттай газар нутгийг хадгалахад шаардагдах хөрөнгө оруулалтыг хангалттай хийж, тогтвортой ашиглах: ТХГН-т оруулах хөрөнгө оруулалтыг өсгөж, бодлогын хэрэгжилтийг сайжруулан, менежментийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх нөхцөл байдлыг тооцдог. БКХО хувилбар нь ТХГН-ийн экосистемийн үйлчилгээний чанар, үр нөлөөг тогтвортой өсгөхөд анхаардаг билээ. БББ болон БКХО хувилбарын талаар дэлгэрэнгүй мэдээллийг 2-р хэсгээс үзнэ үү.

хариулт олохыг зорилоо. Үүнд: а) Экосистем/ТХГН-ийн менежментийн хөрөнгө оруулалтыг сайжруулах нь яагаад Монгол улсын эдийн засгийн тогтвортой хөгжилд эерэг нөлөөтэй вэ? б) Яагаад экосистемийн болон ТХГН-ийн менежментийг сайжруулах нь тогтвортой хөгжлийн нэн тэргүүний

зорилт болж байна вэ? ЗСШ-ний аргыг Бүлэг 3.1-т товч танилцуулав. Судалгаанд Байгалийн аялал жуулчлал (БАЖ), Усалгаатай газар тариалан, Мал аж ахуй, Ундны ус зэрэг голлох дөрвөн салбарын БББ болон БКХО хувилбарын төлвийг гаргахдаа сонгон авсан үзүүлэлтүүдэд суурилсан болно:

Сонгон авсан үзүүлэлтүүд	Зорилтот салбарууд			
	БАЖ	Усалгаатай газар тариалан	Бэлчээр ба мал аж ахуй	Ундны ус
Ажлын байрны өсөлт /салбараар/*	*	*	*	
Орлого, салбарын жилийн дундаж өсөлт*	*	*	*	
Жуулчдын зарцуулалт*	*			
Бүтээгдэхүүний хандлага (хэмжээ, зах зээлийн үнэ)*		*	*	*

Байгалийн Аялал Жуулчлал: ГТБЦГ нь байгалийн хосгүй үзэсгэлэнт нутаг төдийгүй түүх, соёлын дурсгалт газрын хувьд Монгол орны аялал жуулчлалын гол маршрутын нэг болдог. Тус БЦГ нь боржин чулуун өвөрмөц тогтоцтой хад асга, өндөр уул нуруудын сайхнаараа алдартай бөгөөд гольф, явган аялал, усан аялал, морь унах, хаданд авирах зэрэгт тохиромжтой.

Сүүлийн жилүүдэд ГТБЦГ-т аялах жуулчдын тоо 1996-2007 оны хооронд дотоодын жуулчдын тоо 25000-аас 65000 хүртэл, гадаадын жуулчдын тоо 6,000-аас 30,000 болсон өссөн (ҮСХ, 2012). Үүнийг дагаад ГТБЦГ, түүнийг тойрсон аялал жуулчлалын бизнес эрхлэгчид олноор нэмэгдэж байна.

Гэвч ГТБЦГ-ын аялал жуулчлалын орлого 2007 оноос эхлэн буурсан нь аялал жуулчлалын тогтвортой бус үйл ажиллагаа хийгээд 2008 оны санхүүгийн хямрал нөлөөлжээ. 2007-2012 оны хооронд аялал жуулчлал эргэн сэргэсэн ч хурд нь удаан байгааг ГТБЦГ-ын БАЖ нь БББ хувилбараар хэрэгжиж байна хэмээн үзэхэд хүргэж байна. Энэ хугацаанд жуулчид (дотоодын болон гадаадын)-ын тоо жилд дунджаар 4%-иар буурч байжээ. Гэхдээ ГТБЦГ-ын ЭСҮ нь БАЖ-д хувь нэмрээ оруулсаар байгаа юм.

Жишээлбэл, 2011 онд чөлөөт цагаа өнгөрүүлэх болон ажил хэргийн шугамаар ирсэн жуулчдын дундаж зардал харгалзан 581 ам.доллар 914 ам.доллар байжээ (2010 оны судалгаа). 2007-2012 оны хооронд ГТБЦГ болон Хан Хэнтийн ДЦГ- чөлөөт цагаа өнгөрүүлэхээр ирсэн гадаадын иргэдийн зардал дунджаар 122,218 ам.доллар байж, нийтдээ 70.9 сая ам.долларын орлого төвлөрүүлсэн байна. Ирээдүйд дээрх орлого хэдий хэмжээгээр өсөх нь БББ хувилбарыг БКХО хувилбараар солих ЗГ-ын үүрэг амлалтын

хэрэгжилтээс шалтгаалах юм.

2007-2012 оны бууралтын хувь (4%)-иар авч үзвэл 2012-2025 онд аялал жуулчлалын салбарын нийт орлого 10.9 сая ам.доллараас 2025 он гэхэд 6.4 сая ам.доллар болж буурах юм. Харин 4%-иар буурч байгаагаас үүдэн БКХО хувилбарыг хэрэгжүүлж эхэлвэл нийт орлого 2012 онд 10.9 сая ам.доллар байснаас 2015 онд 18.2 сая ам.долларт хүрнэ. БББ хувилбарыг БКХО хувилбараар сольсноор 2012-2015 оны хооронд учирч болзошгүй 81.2 сая ам.долларын алдагдлаас зайлсхийх боломжтой.

ЭСҮ нь БАЖ-ыг тогтвортой хөгжүүлэхэд амин чухал бөгөөд ГТБЦГ-ын аялал жуулчлалын орлогыг тогтвортой нэмэгдүүлэхэд голлох хүчин зүйл болдог. БАЖ-ын орлогыг нэмэгдүүлэх БКХО хувилбарт шилжихэд бодлогын томоохон шинэчлэл хэрэгтэй.

БАЖ-ын салбарын орлогын хуваарилалтыг үнэлэх нь энэхүү судалгааны зорилго биш ч ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй БАЖ-ийн компаниудад жижиг гэр буудлууд, УВ-2 гэх мэт дунд хэмжээний зочид буудлууд, таван одтой Тэрэлж буудал гэх мэт өндөр зэрэглэлийн тансаг зочид буудлууд багтаж байна. Харамсалтай нь одоогоор зочид буудлын салбараас олсон орлогоос ТХГН-ийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх аялал жуулчлалтай холбоотой санхүүгийн механизм байхгүй байна.

Олон улсын болон бүс нутгийн хэмжээний компаниуд гэр буудлыг олноор эзэмшдэг. Үйлчилгээгээ тасралтгүй явуулахын тулд тэд гэр буудлуудын үйлчилгээнд орон нутгийн иргэдээс авч ажиллуулдаг нь орон нутгийн эдийн засагт шууд хувь нэмрээ оруулж байна. Түүнчлэн гадаадын жуулчдын хэрэгцээнд тохирсон олон улсын стандартад нийцсэн үйлчилгээ үзүүлэх зорилгоор орон нутгийн иргэдэд сургалт зохион байгуулдаг.



Нутгийн соёл, заншлыг алдагдуулахгүйгээр нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын сүлжээний хөгжлийг дэмжин ажиллаж байна.

Усалгаатай газар тариалан (ургац). Монгол орны ТХГ-дын адил ХХДЦГ-ын экосистемийн нэг бүрэлдэхүүн хэсэг болсон ГТБЦГ-аас эхтэй экосистемийн үйлчилгээ хийгээд усалгаатай газар тариалангийн хооронд шууд хамааралтай. Монгол улсад ТХГН-т аялал жуулчлал болон уламжлалт мал аж ахуйгаас өөр хэлбэрийн аж ахуй эрхлэхийг хуулиар хориглодог хэдий ч ХХДЦГ болон ГТБЦГ-тай зэргэлдээ оршиж, экосистемийн үйлчилгээнээс ашиг олж буй аж ахуй эрхлэгчид олон байдаг.

ГТБЦГ-ын цэвэр усны экосистемийн үйлчилгээ нь усалгаатай газар тариаланд чухал ач холбогдолтой. Гэвч газар тариалангийн тогтвортой бус үйл ажиллагаа, хангалтгүй хөрөнгө оруулалтын улмаас усалгаатай газар тариалангийн салбарыг БББ хувилбараар хэрэгжиж байна хэмээн үзлээ.

Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ны 2013 оны мэдээгээр олон тооны компани, хувь хүн (3,525) Төв аймаг болон Улаанбаатар хотод газар тариалан эрхэлж байна. Туул голын сав газрын усны менежментийн төлөвлөгөөнөөс үзэхэд Туул голын ойр орчмын 668.7 км² тариалангийн талбайг Туул голын гадаргын болон гүний усаар усалж байна.

Газар тариалан эрхлэгчид өрхийн хэрэгцээний болон арилжааны зорилгоор хүнсний олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Судалгааны зорилгод нийцүүлэн газар тариалангийн бүтээгдэхүүн (өвс, малын тэжээл, үр тариа, рапсын үр, хүнсний ногоо, жимс)-ний цэвэр орлогыг БББ болон БКХО хандлагыг тодорхойлоход ашиглав. ГТБЦГ оршиж буй сумдын 2002-2012 оны газар тариалангийн нийт цэвэр орлого 16.9 тэрбум төгрөг (12 сая ам.доллар³) байна. 2002-2012 оны хооронд нийт бүтээгдэхүүн дунджаар 12.7%-иар өсчээ.

Жилийн дундаж өсөлт болох 12.7%-ийг БББ хувилбарын төлөвийг гаргахад ашиглав. Үүнээс үзэхэд газар тариалангийн бүтээгдэхүүний нийт орлого 2020 онд хамгийн өндөр түвшиндээ буюу 4.9 тэрбум төгрөгт хүрэх юм. Гэвч 2020 оноос эхлэн энэхүү өсөлт (1-10%) буурч эхэлнэ. Энэ нь газар тариалангийн тогтвортой байдлыг дэмжих бодлого, үйл ажиллагааны санхүүжилт дутмаг, усалгааны дэд бүтэц сул, пестицид, химийн бордоог хэтрүүлэн хэрэглэдэг, усны бохирдол гэх мэтээс үүдэлтэй. Дээрх хандлага үргэлжилсээр байвал газар тариалангийн бүтээгдэхүүний нийт

³ 2012 оны ам.долларын ханш 1 ам.доллар=1359.24төгрөг, Монгол банк (2012).

цэвэр орлого БКХО хувилбарт шилжсэний дараах тооцоолсон хэмжээнд хүрэхгүй байх эрсдэлтэй.

Нөгөөтэйгүүр БКХО хувилбарын хүрээнд бий болох газар тариалангийн бүтээгдэхүүний нийт цэвэр орлого 2020 он хүртэл жил бүр 5%-иар өсч, 3,128 сая төгрөгт хүрч цаашид тогтворжих юм. Өнөөгийн БББ хувилбараар бүтээмж тогтвортой бус хийгээд хөрсний элэгдэл, зах зээлийн үнэ буурснаас олон тэрбум төгрөгийн алдагдал хүлээх эрсдэл учирч байна.

Бүтээмж буурснаар хүмүүсийн орлогод нөлөөлдөг. ҮСХ (2013)-ны мэдээнд үндэслэсэн судлаачдын тооцоогоор газар тариалан эрхэлдэг өрхийн орлого 2002-2012 оны хооронд 45.9%-иар өсч, 35.4 сая төгрөгөөс 1,718 сая төгрөгт хүрчээ. Энэ нь ГТБЦГ орших сум, дүүргүүдийн бага орлоготой өрхийн орлогын түвшин юм. Туул Голын Сав Газрын Усны Менежментийн Төлөвлөгөө (2012)-өөр Монгол улсын нийт хүн амын 40% нь гадаргын болон газар доорх усны гол эх сурвалж болсон Туул голын ойр орчмын нутгаар амьдарч байна.

Мал аж ахуй. бэлчээр нь ГТБЦГ орших Батсүмбэр, Баяндэлгэр, Эрдэнэ сумдын мал аж ахуйн салбарын бүтээмжийг тогтвортой байлгахад нөлөөлдөг. Бэлчээргүйгээр мал аж ахуйн салбарын үр ашгийг тооцох боломжгүй билээ. Ялангуяа гантай зун, зудтай өвлийн улиралд бэлчээр маш чухал. Гэвч бэлчээрийн даац хэтэрсэнээс бэлчээрийн экосистем, мал аж ахуйн салбарын бүтээмж аюулд орж байна. ГТБЦГ болон ХХДЦГ-ын орчмын бэлчээрийн менежментийн тогтвортой ашиглалтын байдлыг дээрх ТХГ-дын хамгаалалтын менежменттэй уялдуулахгүй, зөвхөн тухайн аймаг, сумдын захиргаадаас хяналт, зохицуулалт хийж байгаа нь экосистемд сөрөг нөлөө үзүүлж буй БББ хувилбарын тод илрэл юм.

ГТБЦГ орших сумдын мал аж ахуйн салбарт (ж.нь: хонь, тэмээ, морь) олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Мал аж ахуйн бүтээгдэхүүн (ж.нь: мах, сүү, ноос, ноолуур, арьс шир)-ний нийт цэвэр орлогыг БББ болон БКХО хандлагын төлвийг гаргахад ашиглав. 2002-2012 оны хооронд ГТБЦГ орших сумдын мал аж ахуйн салбарын нийт цэвэр орлого 60.9 тэрбум төгрөг (43.4 сая ам.доллар) байжээ. 2002-2012 оны хооронд тус салбарын бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлт 20%, нийт орлого 2002 онд 2.1 тэрбум төгрөг байснаас 2012 онд 13.2 тэрбум төгрөгт хүрчээ. Гэвч ГТБЦГ-ын бэлчээрийн менежментийн тогтвортой зохицуулалт байхгүйгээс бэлчээрийн даац хэтэрч, доройтон мал аж ахуй, зэрлэг амьтдын амьдрах орчин нөхцөл болсон бэлчээр, усны хомсдол үүсч

байна. Бэлчээрийн доройтол үүссэнээс гарч болох үр дагаварыг Өвөр Монголын жишээн дээр үзвэл, Зао (2014) судлаачийн мэдээгээр Өвөр Монголд нэг га талбай бэлчээрт 4.5 хонь гэсэн зарчмыг баримталдаг ч сүүлийн жилүүдэд энэ тоо 5 болж өссөнөөс хонины жин мэдэгдэхүйц буурч (3 жилийн дотор), зах зээлийн үнийг тогтвортой байлгахад хонины махны хэмжээг бууруулахгүй байх тулд илүү олон хонь өсгөх шаардлага болсон байна.

БББ хувилбар нь эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой байдлыг алдагдуулдаг. Жишээлбэл, 2012 оны мал аж ахуйн нийт цэвэр орлого 13.2 тэрбум төгрөг болж жилийн дундаж өсөлт 20% (жилийн дундаж өсөлтийн хувь 2002-2012) байв. Цаашид энэ байдлаар зах зээлийн нийт үнэ 81.7 тэрбум төгрөг (58.3 сая ам.доллар)-т хүрэх боломжтой. Гэвч энэхүү орлого нь байгаль орчны асар их хохирлыг дагуулах болж байна.

Энэхүү судалгаанд статистикийн зарим мэдээллийг ашигласан боловч ГТБЦГ-ын мал аж ахуйн салбарын нэг га талбайд бэлчээрлүүлэх малын тоо, малын дундаж жин, үнэ, эрэлт, нийлүүлэлтийн параметрууд г.м. чанарын болон тоон судалгаа байхгүй байлаа. Тухайлбал БББ хувилбараар 2020 оноос эхлэн орлого нь аажмаар (5%) буурч эхэлнэ. Бууралтын хувийг ашиглан мал аж ахуйн салбарын ирэх жилүүдийн БКХО хувилбарыг хэрэгжүүлээгүйгээс үүдэх алдагдлыг тооцов.

БКХО хувилбараар нийт ашиг 2030 он гэхэд 48.3 тэрбум төгрөгт хүрч тогтворжино. БКХО хувилбарыг хэрэгжүүлэхэд бодлогын шинэчлэл, хангалттай хөрөнгө оруулалт шаардлагатай. БББ хувилбар нь олон тэрбум төгрөгийн алдагдалд хүргэх юм.

Туул голын сав газрын усны менежментийн төлөвлөгөө - ТГСГУМТ (2012)-ний дагуу БКХО хувилбарт шилжиж эхэлсэн. Энэ нь мал аж ахуйн салбарын менежментийг сайжруулахад чухал нөлөө үзүүлж байна. Гэвч ГТБЦГ болон ХХДЦГ-ын үйл ажиллагааны менежментийг сайжруулах усны эх сурвалж, бусад нөөцийг хамгаалах тусгайлсан зүйл заалт одоогоор байхгүй байна.

Мал аж ахуйн салбарын бүтээмж буурах нь иргэдийн орлогод шууд нөлөөлдөг. ҮСХ (2012)-ны мэдээнд суурилсан судлаачдын тооцоогоор мал аж ахуй эрхэлж буй өрхийн жилийн дундаж орлогын өсөлт 2002-2012 оны хооронд 26.5%-тай, 971 сая төгрөг байснаас 10,139 сая төгрөг болтлоо өсч, нийтдээ 52,153 сая төгрөгийг олсон байна.

Ундны усны хангамж. Улаанбаатар хотын оршин суугчид ГТБЦГ-ын цэвэр усны экосистемийн үйлчилгээг хамгийн ихээр хүртдэг. Туул гол нь ГТБЦГ-аас эх авч Улаанбаатар хотын дундуур дайран, нийтдээ 704 км урсан Сэлэнгэ мөрөнд цутгадаг. Ойролцоогоор 49.84 км² талбайг эзэлдэг. Хотын хүн амын төлөвлөөгүй өсөлт нь ундны усны хангамж зэрэг олон асуудлыг дагуулж байна.

Ус сувгийн удирдах газар (УСУГ) Улаанбаатар хотыг усаар хангах үүрэгтэй. УСУГ-ын өнөөгийн ажиллаж буй хэмжээ 177,500 м³/хоног ба нийт 230,000 м³/хоног хүчин чадлаар ажиллах боломжтой юм; Хотын төлөвлөгөөгөөр хүн ам ихээр шилжин ирж байгаагийн улмаас энэхүү хэрэгцээ 240,000 м³/хоног хэмжээгээр нэмэгдэж, 2030 он гэхэд 510,700 м³/хоног болох юм.

Монгол улсад нэг литр усны үнэ өөрийн эдийн засаг болон экологийн өртгөөс доогуур байгаа нь усыг замбараагүй хэрэглэх нөхцөлийг бүрдүүлдэг. 2012 оны УСУГ-ын судалгаагаар гэр хорооллын иргэд 681.8 куб метр усыг нэг куб метрийг нь 5,294.8 төгрөг (3.9 ам.доллар)-өөр худалдан авчээ. Гэвч бодит үнэ нь 911.6 төгрөг (0.671 ам.доллар) байна. Энэ нь БББ хувилбар явагдаж буйн илрэл юм.

Гэвч судалгаанаас үзэхэд ундны усны хязгаарлагдмал нөөц, хангамжаас үүдэн цаашид усны үнэ огцом өсөх хандлагатай байна. Цэвэр усны экосистемийн менежмент, усны хамгаалалтанд оруулах санхүүжилт хангалтгүй байгаа нь БББ хувилбарын илрэл юм. ТГСГУМТ нь Туул голын усны хагалбар орчмын ил бохирдол, хөрсний элэгдлийг бууруулахад чиглэгдэж байна.

Өнөөгийн БББ хувилбараар 2002-2012 оны хооронд жилийн дундаж өсөлт 5.5% (ҮСХ, 2012) ба энэ өсөлт 2025 хүртэл үргэлжилнэ. Түүнээс хойш Усны хангамжийн орлого буурч 2035 онд эргээд 2012 оныхтой дөхөж ирэх юм. Хүний зохисгүй үйл ажиллагаанаас үүдэн илүү их алдагдал хүлээж болзошгүй.

БКХО хувилбараар усны зах зээлийн үнэ жил бүр 5.5%-иар өсч, 2035 онд 185.1 тэрбум төгрөгт хүрнэ. Хэрэв өнөөгийн БББ хувилбар үргэлжилсээр байвал болзошгүй алдагдал 872.2 тэрбум төгрөгт хүрэх юм. БББ хувилбарыг БКХО хувилбараар сольсноор үүнээс сэргийлэх боломжтой.

Энэхүү судалгаанд ашиг, алдагдлын ирээдүйн төлвийг харуулав. Гэхдээ усны үнэ, түүнээс олох орлого нь усны нөөцийг хамгаалан, тогтвортой хангамжийг бий болгоход нэн чухал хүчин зүйл юм.



Бүлэг 4-т дүгнэлт, санал зөвлөмжийг багтаав. ГТБЦГ-ын ЭСҮ нь бүс нутгийн эдийн засагт ихээхэн хувь нэмэр оруулж буйг харуулах баримт олон байна. Түүнчлэн аялал жуулчлал, мал аж ахуй, усалгаатай газар тариалангийн үйлдвэрлэлд нэн даруй өөрчлөлт хийх шаардлагатай. БББ хувилбарын экосистемд үзүүлж буй сөрөг нөлөө улам бүр илэрхий болж байна. Голлох дөрвөн салбарын орлогыг тооцоход ашигласан арга зүйг тус тусын бүлэгт тайлбарлав.

Бүлэг 4.2-т судалгаанд хамруулсан голлох дөрвөн салбарын бодлогын санал, зөвлөмжийг тусгав. Үүнд: Байгалийн аялал жуулчлал, усалгаатай газар тариалан, бэлчээр, мал аж ахуй, ундны усны хангамж. Үүнээс гадна бодлогын тодорхой шинэчлэлийг дээрх салбаруудад хийх нь экосистемийн менежменттэй холбоотой төслүүд, тэр дундаа салбарын хөрөнгө оруулалтын бодлого, зарчмыг санхүүжүүлэн хэрэгжүүлэх чухал алхам болох юм.

1. ОРШИЛ

Даян дэлхийн байгаль орчны сан болон НҮБХХ-ийн санхүүжилтийн дэмжлэгтэй хэрэгжиж буй “Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх нь (ТХГНСБ)” (2010-2015) төсөл нь Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамтай хамтран ажиллаж байна. Энэхүү төслийн зорилго нь Монгол орны ТХГН-ийн сүлжээний санхүүгийн тогтвортой байдал, менежментийн үр дүнг дээшлүүлэх явдал юм. Энэхүү төсөл эхлэх үед ТХГН-ийн сүлжээнээс олж буй үндэсний жилийн орлого 2.5 сая ам.доллар байв. Тиймээс ТХГН-ийн санхүүжилт дутмаг байдлыг нөхөж, урт хугацаанд тогтвортой байлгах үүднээс ТХГН-ийн сүлжээний менежмент, санхүүгийн чадамжийг хөгжүүлэх, ТХГ-дын удирдлага, орон нутгийн иргэдийн бүлэг, нөхөрлөл, орон нутгийн удирдлага, ТББ-ууд болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, бэхжүүлэхийг зорьж байна.

Энэхүү төсөл гурван үндсэн ач холбогдолтой: (1) ТХГН-ийн тогтвортой менежментийг бий болгож, түүнийг санхүүжүүлэх үндэсний хэмжээний бодлого, хууль эрхзүй, орчныг бэхжүүлэх; (2) ТХГН-ийн сүлжээг үр дүнтэй менежментийг бүрдүүлэх боловсон хүчний чадамжийг дээшлүүлэх; (3) Санхүүгийн механизмыг тогтворжуулан, хамтын ажиллагааг сайжруулах замаар ТХГН-ийн менежментийг үр дүнтэй стратеги, санхүүжилтээр хангах.

Судалгааны зорилгын хүрээнд Монгол улсын ТХГН-ийн сүлжээ (ний эдийн засагт оруулж буй хувь нэмрийг үнэлж, Горхи Тэрэлжийн БЦГ, Их Нартын БНГ болон Орхоны хөндийн БЦГ-ын судалгааг холбон авч үзэв. Мөн ТХГН-ийн сүлжээний судалгааны мэдээллүүдийг хамруулан, тодорхой ТХГ-дын судалгааг тусад нь илтгэн, хэвлэх болно.

Энэхүү судалгаа нь НҮБХХ-ийн ТХГНСБ төслийн хүрээнд ГТБЦГ-ын ЭСҮ-ний сонгон

авсан салбаруудын бүтээмжийн нөлөөлөл, үйл ажиллагааны ашиг алдагдалын хэмжээг үнэлэх зорилготой юм. Тус судалгаанд ТХГН-ийн экосистемийн менежментийн “муу” “сайн” хувилбар буюу “Бизнес Байгаагаараа Байх (БББ) хувилбар”, “Байгалийн Капиталд Хөрөнгө Оруулах (БКХО) хувилбар”⁴-ыг харьцуулан авч үзлээ. Энэ хүрээнд МУТХГН-ийн ЭСҮ-ний үр ашигтай үйл ажиллагааны эдийн засгийн боломж, эрсдэлийн талаар бодлого тодорхойлогчид болон бизнес эрхлэгчдэд ойлголт, мэдээлэл өгөхөд оршино. Мөн энэхүү тайлан хэвлэгдэн гарснаар МУТХГНС-ний менежментийн төлөвлөгөө, санхүүгийн стратегийг сайжруулах БОНХАЖЯ-ны бодлогод эдийн засаг, нийгмийн томоохон баримт болно хэмээн найдаж байна.

⁴ Бизнес Байгаагаараа Байх хувилбар (БББ хувилбар) – тусгай хамгаалалттай газар нутагт оруулж буй хөрөнгө оруулалт хангалтгүй хэвээр байх: ТХГН-т оруулж буй хөрөнгө оруулалт, менежментийн өнөөгийн хандлага хийгээд цаашид энэ байдлаар үргэлжилбэл ямар нөхцөл байдал үүсэхийг харуулдаг. Үүний дүнд одоо байгаа болоод цаашид хамгаалалтанд багтах газруудад хөрөнгө оруулалт үгүй болж, менежмент нь улам сулрах юм. Хөрөнгө оруулалт хангалтгүй байгаагаас биологийн төрөл зүйл, экосистемийн менежментийг сайжруулах боломжгүй: Тусгай хамгаалалттай газар нутаг нь экосистемийн нэн чухал үйлчилгээ (тухайлбал: усны нөөц, усны хагалбарыг хамгаалах, үерийн аюулаас хамгаалах)-г үзүүлдэг боловч тэдгээрийн чанар, үр нөлөө өдөр ирэх тусам багассаар байна. Байгалийн Капиталд Хөрөнгө оруулах хувилбар (БКХО хувилбар) – Тусгай хамгаалалттай газар нутгийг хадгалахад шаардагдах хөрөнгө оруулалтыг хангалттай хийж, тогтвортой ашиглах: ТХГН-т оруулах хөрөнгө оруулалтыг өсгөж, бодлогын хэрэгжилтийг сайжруулан, менежментийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх нөхцөл байдлыг тооцдог. БКХО хувилбар нь ТХГН-ийн экосистемийн үйлчилгээний чанар, үр нөлөөг тогтвортой өсгөхөд анхаардаг билээ. БББ болон БКХО хувилбарын талаар дэлгэрэнгүй мэдээллийг 2-р хэсгээс үзнэ үү.



2. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ, ЭКОСИСТЕМ, ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ БА ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР

Энэхүү бүлэгт ТХГН, экосистем, экосистемийн үйлчилгээ (ЭСҮ)-ний ерөнхий ойлголт, тэдгээр нь хоорондоо хэрхэн холбогддог, ГТБЦГ-ын ерөнхий мэдээлэл, санхүүгийн тулгамдсан асуудлыг тусгав.

Дэлхийн байгаль хамгаалах холбооноос⁵ ТХГН гэж “биологийн төрөл зүйлийг хамгаалах, соёлын өвийг хадгалах зорилгоор хуулиар хамгаалсан газар\далай тэнгисийн нутгийг хэлнэ” хэмээн тодорхойлжээ.

Биологийн төрөл зүйлийн тухай конвенц(1992)-д ТХГН гэдэг нь “тодорхой төрөл зүйлийг хамгаалах үүднээс зохион байгуулж, журамласан газар зүйн бүс нутаг юм.” гэжээ. Гэвч эдгээр экологийн тодорхойлолт нь ТХГН-ийн эдийн засаг, нийгмийн асуудлыг тодотгон харуулж чадахгүй. Гэхдээ ТХГН нь хуурай газар, далай тэнгист амьдарч буй амьтан, ургамлын төрөл зүйлийг хамгаалахад ихээхэн ач холбогдолтой болох ерөнхий ойлголтыг харуулж байна.

Мянганы экосистемийн үнэлгээгээр⁶ ТХГН нь хүн төрөлхтний ахуй амьдрал, хөгжил дэвшилд

амин чухал үүрэгтэй экосистемийн үйлчилгээгээр хангадаг гэжээ. Үүнд: цэвэр ус; үер, салхины тэнцвэртэй байдал; загас үржүүлэг; тоос хүртээлт; нүүрстөрөгчийн шингээлт. Энэхүү тодорхойлолт нь эдийн засаг, нийгмийн хувьд илүү тохиромжтой юм.

Экосистем гэдэг нь хүрээлэн буй орчны байгалийн амьд биет (амьд зүйлс) болох бүхий л амьтан, ургамал, бичил биетнүүд болон амьгүй биет (амьгүй зүйлс)-ийг хамтад нь агуулдаг байгалийн нэгж юм. Энэ нь нэг орчинд амьдарч, харилцан хамааралтай оршдог организмуудаас үл хамаарах бүхэл бүтэн систем билээ. ТХГН нь экосистемийн үйлчилгээг хадгалан хамгаалах, тогтвортой ашиглалтыг зохицуулахад чухал нөлөөтэй. Экосистемийн үйлчилгээ нь мод, хөрсний бордоо зэрэг модон эдлэл, тариалангийн талбайд чухал нөлөөтэй байгалийн үнэт хөрөнгө юм (Шкротер, 2005). ГТБЦГ нь биологийн олон янз байдал, экосистемд хосгүй үнэт орчин болдог.

Энэхүү судалгаанд Хүснэгт 1-т үзүүлсний дагуу ГТБЦГ-ын экосистемийн үйлчилгээг судлахыг зорилоо.

⁵ IUCN 1994 – Guidelines for PA Management Categories.

⁶ <http://www.millenniumassessment.org>

Хүснэгт 1: ГТБЦГ-ын экосистемийн зорилтот үйлчилгээ

МУТХГНС-ний экосистемийн үйлчилгээ	ГТБЦГ-ын судалгаанд тусгасан байдал
Байгалийн үзэсгэлэнт газрууд (явган аялал, байгалийн үзэсгэлэн, ан амьтан ажиглах аялал)	•
Цэвэр ус (усны хагалбар)	•
Бэлчээр (өвс)	•
Хоол хүнс (ж.нь: малын тэжээл, үр тариа, мах, хүнсний ногоо)	•
Хүний эрүүл мэнд (ундны ус)	•

ТХГН-ийн экосистемийн үр ашиг нь урт хугацаанд, өргөн хүрээнд хуваарилагддаг, Эх дэлхийгээс бий болсон зах зээлийн бус хүчин зүйл гэдгээрээ онцлог (хэдийгээр зарим аялал жуулчлал, ус, нүүрсхүчлийг шингээгч зэрэг нь зах зээлээс хараат ч гэлээ). Одоогоор ЭСҮ-нд ямар нэгэн хязгаарлалт байхгүй. Гэвч нөөцийг шавхан, зах зээлээр удирдуулан ашиг олж буй нөхцөлд эрчимжсэн газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, фермер, мод бэлтгэл гэх мэт салбар нь ЭСҮ-нд аюул учруулж болзошгүй юм.

ГТБЦГ нь Улаанбаатар хотоос зүүн хойш 80 км зайтай оршдог. Далайн түвшнээс дээш 1600 метрт орших өндөрлөг газар, уул нурууд сүрлэг харагдах ба явган аялал, хаданд авирах, сэлэх, завиар зугаалах, морь унах, өвлийн улиралд цанаар гулгахад тохиромжтой.

Тус БЦГ-т сонин содон тогтоцтой хад олон байх бөгөөд түүн дотор тогтоц, хэлбэрээрээ нэрлэгдсэн алдартай хоёр хад бий. Үүнд: Мэлхий хад, Өвгөн хадыг нэрлэж болно.


Тэрэлж нь 1964 онд байгуулагдсан аялал жуулчлалын ууган бүс нутаг бөгөөд 30 жилийн

дараа Горхи-Тэрэлжийн БЦГ-ын нэг хэсэг болсон юм. Зүүн хойд талаараа Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгийн 1.2 сая га талбайг эзлэн оршдог Хан Хэнтийн ДЦГ-тай хил залган, оршдог.

ГТБЦГ-ын ЭСҮ нь Төв аймаг болон Улаанбаатар хотын эдийн засгийн үйл ажиллагаатай шууд холбогддог. Төв аймгийн Баяндэлгэр, Эрдэнэ, Батсүмбэр, Улаанбаатар хотын Баянзүрх, Налайх дүүргийн газар нутгаас хамардаг. Үүнийг Хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2. ГТБЦГ-ын ЭСҮ-г хүртдэг сум, дүүрэг	
Төв аймаг	Батсүмбэр сум
	Баяндэлгэр сум
	Эрдэнэ сум
Улаанбаатар хот	Баянзүрх дүүрэг
	Налайх дүүрэг

Энэхүү судалгаа нь ГТБЦГ-ын ЭСҮ-ний Төв аймаг болон Улаанбаатар хотын холбогдох сум, дүүрэгт оруулж буй эдийн засгийн ашгийг тооцоход чиглэсэн боловч эдийн засгийн үр ашиг нь Улаанбаатар хот болон Төв аймгийн захиргааны хилийн шугамаар хязгаарлагдахгүй юм. ГТБЦГ-ын байршлыг доорх газрын зурагт үзүүлэв.





Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжээд удаагүй байгаа төв болон зүүн европын орнуудын адил Монгол улсын эдийн засаг уламжлалт салбаруудын үйл ажиллагаанд тогтож байгаа билээ. Энэхүү үйл явц нь Монгол орны байгалийн капитал, ЭСҮ-г доройтуулах шалтгаан болж байна. ТХГН-ийн экосистем нь Монгол улсын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд зайлшгүй шаардлагатай арвин хийгээд үнэгүй үйлчилгээгээр хангадаг. Одоогоор ЭСҮ-г зүй зохисгүй ашигласны сөрөг нөлөө мэдэгдэхүйц нэмэгдэж байна. Монгол улс нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд хүрэхэд энэхүү нөхцөл байдал саад болж байгаа юм.

1.2. ГТБЦГ-Т УЧИРЧ БУЙ АЮУЛ

НҮБХХ-ийн ТХГНСБ төсөл (1999)-ийн үнэлгээгээр Монгол орны экосистемийн биологийн олон янз байдалд зарим төрлийн аюул учирч байна. Тэдгээрээс хамгийн их анхаарал татаж буй хүчин зүйлсийг дурдвал:

Хотжилт ба хөгжил: Өнгөрсөн 15 жилд хөдөөнөөс хот, суурин газарт ирж суурьших хүмүүсийн тоо өсч, ТХГН-ийн ачааллыг нэмэгдүүлж байна. Монгол улсын хүн амын 40 орчим хувь нь оршин сууж буй Улаанбаатар хотын дэд бүтцийн хөгжил нь ТХГН болон биологийн олон янз байдлыг доройтуулахад хүргэж байгаа нь томоохон асуудал болж байна. Хотжилт тэлсний сөрөг нөлөөг харуулах хамгийн тод жишээ бол ГТБЦГ болон Хан Хэнтийн ТХГ-д юм.

Төлөвлөгөөгүй аялал жуулчлал: Сүүлийн жилүүдэд ДЦГболон БЦГ-дадгэр баазууд барих нь олширчээ. 2006 оны судалгаагаар Богд Хан уулын ДЦГ, Горхи-Тэрэлжийн БЦГ, Хөвсгөлийн БЦГ, Говь Гурван Сайханы БЦГ, Хангайн нурууны есөн БЦГ-т голчлон төвлөрсөн 484 жуулчны бааз ТХГН дээр үйл ажиллагаа явуулж байна. ТХГН-ийн зохицуулалт муугаас жуулчны баазын тоо 2002 онтой харьцуулахад 2008 онд тав дахин өсч, 2008 онд Монгол улсад гадаадын нийт 400,000 орчим жуулчид ирснээс 100,000 хүрэхгүй жуулчин ТХГН-аар аялсан ажээ. Үүний зэрэгцээ дотоодын жуулчдын тоо сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц өсч байна. Гэр баазууд нь жуулчдын анхаарлыг татдаг бас нэгэн чухал зүйл боловч орчны хог хаягдал, зохион байгуулалтгүй шавааралдуулж барих зэрэг нь ТХГН-т асуудал болдог. Аялал жуулчлалаас ТХГН-т хөрөнгө оруулах зарчим, дүрэм журам, хэрэгжилт хангалтгүй байна.

Бэлчээрийн даац хэтрэх (Малын тоо толгой өсч байгаа)Бэлчээрийн даац хэтрэх нь мал, амьтны халдварт өвчнөөс эхлээд олон эрсдэл дагуулдаг. Өнөөдөр Монгол улсад малын тоо толгой хэт олширч (33 саяас 43 сая болж өссөн), ТХГН болон түүний ойр орчмын бэлчээрт ноцтой хөнөөл учруулж байна. ДЦГ -аас бусад ТХГН-т мал бэлчээхийг зөвшөөрсөн байдаг. Тухайлбал, Алтай Саяны ТХГН-т зөвшөөрөгдсөн хэмжээнээс гурав дахин олон мал бэлчиж байгаа аж. Ийнхүү бэлчээрийн даац хэтэрч буй нь Үндсэн хуульд заасан “бэлчээрийг нийтээр ашиглах” бодлогын үр дүн юм.

Ой мод багасах: Хууль бус мод бэлтгэл нэмэгдэж, нийт бэлтгэсэн модны 85 гаруй хувийг Улаанбаатар хотын гэр хорооллын айлууд түлшинд хэрэглэж байна. Монгол улсын нийт газар нутгийн 6.5% буюу 10,252,000 га талбайг ой мод эзэлдэг. 1990-2000 оны хооронд ой модны талбай жилд дунджаар 82,700 га буюу 0.72% хувиар буурч байна. Харин 2000-2005 оны хооронд ой модны эзлэх талбай жилд дунджаар 0.77%-иар өссөн ч 1990-2005 онд Монгол улс нийт ой модны 10.8% буюу 1,240,000 га талбайг ой модгүй болжээ.

1.3 ГТБЦГ-Т ТУЛГАРЧ БУЙ САНХҮҮГИЙН АСУУДАЛ

ГТБЦГ-ын санхүүгийн ерөнхий судалгааг багтаав. 2009 онд боловсруулсан ТХГН-ийн сүлжээний Санхүүгийн Тогтвортой Байдлын Дүн мэдээ (FSS-C)-гээр ТХГН-ийн үйл ажиллагааны жилийн төсөв 1.3 сая ам.доллар байна гэсэн тооцоо гарчээ. МУТХГН-ийн санхүүгийн хэрэгцээ 7.5 сая ам.доллар байсан бөгөөд үндсэн болон оновчтой түвшний⁷ хэрэгцээнд тус бүр 10 сая ам.доллар шаардлагатай. Тиймээс үндсэн болон оновчтой түвшний хэрэгцээнд тус бүр 7.5 сая ам.долларын санхүүжилттэй, 5 сая ам.долларын санхүүжилт дутуу орж байна.

Санхүүгийн тогтвортой байдлын дүн мэдээгээр өнөөгийн санхүүжилт нь байгаль хамгаалах үндсэн

⁷ Менежментийн Үндсэн Түвшин гэдэг нь тусгай хамгаалалттай газар нутаг дахь экосистемийн тогтвортой үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд байгаль хамгааллын гол хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн хамгийн бага түвшинг илэрхийлдэг. Менежментийн Оновчтой Түвшин гэдэг ньТХГН-ийн экосистемийг хамгаалах, тогтвортой байлгах үйл ажиллагааны бүх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн түвшин юм.Нийт шаардлагатай санхүүжилт, хүний нөөц, тоног төхөөрөмж, бусад нөөц баялгуудын тохиромжтой төлвийг тодорхойлохыг ‘Оновчтой түвшин’ гэнэ (СРМ, 2002). Энэ нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн стандартын дагуу тусгай хамгаалалттай газар нутгийн богино, дунд, урт хугацааны зорилтыг хэрэгжүүлэхэд үр дүнгээ өгөх юм (Flores et al., 2008).

үйл ажиллагаанд шаардлагатай нийт дүнгийн 32 хувьтай тэнцэж байна. Санхүүжилт дутмаг байдал нь БББ хувилбарын илрэл юм. Өнөөгийн санхүүжилтийн тоймыг Хүснэгт 3-т үзүүлэв. ЗГ-

аас ГТБЦГ-ыг хамгаалахад шаардлагатай нийт зардлын хорь хүрэхгүй хувьд хөрөнгө оруулалт хийж байна.

Хүснэгт 3. ГТБЦГ-ын санхүүгийн нөхцөл байдал (2014).

Санхүүжилт (сая төгрөг)	Төгрөг	Жил бүрийн МТ-ний зардал /төгрөг/	Үйл ажиллагааны зардал 75%	Хөрөнгө оруулалт 25%	Ирэх 4 жилийн дутуу санхүүжилт
Ирэх 4 жилийн МТ-ний санхүүжилт	1,471,000,000	367,750,000	275,812,500	91,937,500	167,750,000
Одоогийн сар бүрийн орлого (МТ-гүй)	200,000,000				

Эх сурвалж: ГТБЦГ-ын менежментийн төлөвлөгөө 2014.

ГТБЦГ-ын бүсэд аялал жуулчлалаас ихээхэн орлого орж ирдэг нь цаашдаа ч ихээхэн ач холбогдолтой хэвээр байна. Гэвч БАЖ-ын урт хугацааны

менежмент, аялал жуулчлалаас орж буй орлогын төрөлжилтөөс хамаарах нь дамжиггүй.



3. ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БЦГ-ЫН ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

Энэхүү бүлэгт Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар (ГТБЦГ)-ын ЭСҮ-ний менежментэд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр салбарын бүтээмж, хүн амын аж амьдралд хэрхэн сайнаар нөлөөлж буйг нотлон харуулах юм. Мөн судалгааны арга зүйг товч танилцуулж, байгалийн аялал жуулчлал (БАЖ), усалгаатай газар тариалан, мал аж ахуй, ундны ус гэсэн голлох салбаруудыг авч үзнэ.

3.1 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгаандаа “Зорилтот Салбарын Шинжилгээ” (ЗСШ)-ний аргыг ашиглав. ЗСШ нь экосистемд чиглэсэн уламжлалт судалгааны арга биш, 2014 оны нэгдүгээр сараас албан ёсоор хэрэглэж эхэлсэн салбарт суурилсан судалгааны арга юм. ЗСШ нь салбарын хөгжил, хөрөнгө оруулалтын бодлогод улс төрчдийн хариуцлагыг

илүүтэй холбон авч үздэг.

ЗСШ нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн практик, экосистем, бусад хүчин зүйлс, салбарын холбогдох бүтээгдэхүүний гарц (үнэ) зэргийн эдийн засгийн харилцан хамаарлыг судалдаг. Тус хандлага нь дараах зүйлд чиглэгдэнэ. Үүнд: а) экосистемийн доройтол нь салбарын бүтээмж, түүнээс олох орлогыг хэрхэн бууруулдаг; б) алдагдлаас зайлсхийх, экосистемд ээлтэй менежментийн эдийн засгийн ашгийг тооцдог. Бизнес байгаагаараа байх хувилбар буюу БББ хувилбар, Байгалийн капиталд хөрөнгө оруулах хувилбар буюу БКХО хувилбар гэсэн хоёр өөр хувилбар нь экосистемийн ашигтай байдлын үнэ цэнийг харуулан, шинжлэх үйл ажиллагааг хялбарчлахад ашиглагддаг. Ундны усны салбар дахь БББ болон БКХО хувилбарын энгийн жишээг Хүснэгт 4-т үзүүлэв.

Хүснэгт 4. Ундны усны одоо хэрэгжиж буй хувилбарын шинж чанар: БББ болон БКХО хувилбар

БББ ХУВИЛБАР	БББ ХУВИЛБАР
<ul style="list-style-type: none"> Усны эх үүсвэрийн тогтворгүй менежмент; Сул менежментээс шалтгаалсан нуур, горхи гэх мэт гадаргын ус хурдан хугацаанд ширгэж байгаа; Хүн ам, малын тоо тогтворгүй бөгөөд хяналтгүй; Төрийн өмчит рашаан сувиллын газрын өнөөгийн бизнесийн загвар алдагдал ихтэй; Малын тоо толгой өсч буйгаас үүдэлтэй байгаль орчны доройтлын үед Аргаль, угалз зэрэг зэрлэг амьтдын уух ус хомсдож байгаа; Усны хэмжээ, чанарт хийсэн шинжлэх ухаан, эдийн засгийн судалгаа шинжилгээ дутмаг байгаагийн улмаас ус хямд үнэтэй байна; 	<ul style="list-style-type: none"> Усны эх үүсвэрийн тогтворгүй менежмент; Сул менежментээс шалтгаалсан нуур, горхи гэх мэт гадаргын ус хурдан хугацаанд ширгэж байгаа; Хүн ам, малын тоо тогтворгүй бөгөөд хяналтгүй; Төрийн өмчит рашаан сувиллын газрын өнөөгийн бизнесийн загвар алдагдал ихтэй; Малын тоо толгой өсч буйгаас үүдэлтэй байгаль орчны доройтлын үед Аргаль, угалз зэрэг зэрлэг амьтдын уух ус хомсдож байгаа; Усны хэмжээ, чанарт хийсэн шинжлэх ухаан, эдийн засгийн судалгаа шинжилгээ дутмаг байгаагийн улмаас ус хямд үнэтэй

Үе шат ба мэдээллийн хүртээмжтэй байдал

Мэдээллийн олдоцтой байдлаас хамааран ЗСШ-ний үнэлгээ хийхдээ дараах үе шаттайгаар ажиллав (ГТБЦГ):

1. Судалгааны хамрах хүрээг тодорхойлох: ГТБЦГ-ын бодлогын асуудлууд;

а) Экосистемийн менежмент дэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь яагаад эдийн засагт чухал нөлөөтэй вэ?

б) Салбарын экосистемийн менежментийн бодлогыг шинэчлэх нь яагаад нэн тэргүүний асуудал болж байна вэ?

2. ҮСХ болон сонгон авсан үзүүлэлтүүдийн

- хүрээнд цуглуулсан мэдээлэл, анхдагч эх сурвалжид үндэслэн БББ хувилбарын судалгаа, БКХО хувилбарын боломжит үр дүнг тодорхойлох
3. Үзүүлэлтүүдийг сонгох (цуглуулсан мэдээлэл болон оролцогч талуудын хэлэлцээрт суурилсан).
 4. БББ болон БКХО хувилбарыг тодорхойлох, үнэлэх.
 5. Бодлого, менежментийн зөвлөмжийг боловсруулах.

Үзүүлэлт

Мэдээллийн олдоцтой байдлаас хамааран БББ болон БКХО хувилбарыг үнэлэхэд дараах үзүүлэлтүүдийг сонгон авсан болно. Үзүүлэлтүүдийг Хүснэгт 4-т жагсаав. Сонгон авсан салбарууд болон дэд салбаруудад доорх бүх үзүүлэлт тохирохгүй учир үзүүлэлтүүдийг тохиромжтой салбарт нь ашигласан болно. Үндэсний Статистикийн Хорооны мэдээлэл зонхилсон ба бусад эх сурвалж хязгаарлагдмал байв. Энэхүү судалгаанд ашигласан үзүүлэлтийг (*) гэж тэмдэглэв. Хүснэгт 4-т үзүүлэв.

Хүснэгт 4. БББ болон БКХО хувилбарыг тооцоход ашигласан салбарын үзүүлэлтүүд
Ажлын байрны өсөлт (шууд болон шууд бус нөлөөлсөн)*
Орлого, дэд салбарын жилийн дундаж өсөлт *
Санхүүгийн хүчин зүйлс (засгийн газрын татварын жилийн орлого)*
Байгаль орчны татвараас орох жилийн орлого
Гадаад валютын орлого (жил бүрийн, экспортоос олох)
Салбарын хөрөнгө оруулалт (засгийн газар)
Салбарын хөрөнгө оруулалт (хувийн хэвшил)*
Жуулчдын зарцуулалт*
Байгаль орчныг доройтуулснаас үүдэлтэй зардал (БББХ-ын үр дүнд)*
Байгаль орчныг доройтуулснаас үүдэлтэй зардлаас зайлсхийх (БКХОХ-ын үр дүнд)
Бүтээгдэхүүний хандлага (хэмжээ, үнэ)*
Салбарын бүтээгдэхүүний хандлага (ДНБ-д эзлэх хувь)
Байгалийн капиталын өөрчлөлт (ж.нь. БКХОХ ба хамгаалалтанд авах)*

БББ болон БКХО хандлагыг тодорхойлох

Сонгон авсан салбаруудад хийсэн экосистемийн үнэ цэнийн талаарх мэдээллийг БББ болон БКХО хувилбаруудад үндэслэн ангиллаа. Биологийн олон янз байдал болон экосистемийн үнэ цэнэ тогтвортой биш боловч орчны доройтол, тогтвортой менежмент, бусад нөлөөлөгч хүчин зүйлсийн хувьсагчдаар тодорхойлох боломжтой юм.

БББ хандлагаар өнөөгийн бүх үйл ажиллагааг бус ЭСҮ-г доройтуулж буй үйл ажиллагааг авч үзсэн. БББ хувилбар нь цаашдын хор уршгаас илүүтэй богино хугацааны (e.g., < 10 жил) хожоонд илүүтэй анхаарч, экосистемийн үнэ цэнийг өчүүхэн бага гэж үзэх, үл хайхрах хандлагатай байдгийн улмаас экосистемийг доройтуулдаг. БКХО хувилбарын хувьд урт хугацааны ашгийг илүүд үздэг бөгөөд үнийн асуудалд уян хатан ханддаг. ЭСҮ-г тогтвортой байлгаснаар бодлого боловсруулагчдад мэдрэгдэхүйц экосистемийн урт хугацааны (> 10 жил) бараа, үйлчилгээг бий болгодог. БКХО нэртэй үйл ажиллагаа нь үгээр бус үйлдлээрээ экосистемийн тогтвортой байдлыг дэмжих урт хугацааны үр өгөөжид анхаарсан илүү практик үйл ажиллагаа юм. БКХО үйл ажиллагаанд усны хагалбарын менежмент, ойн аж ахуй, мал

аж ахуйн төрөлжсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэх арга технологи, сөрөг нөлөө багатай мод бэлтгэл, уул уурхай, байгальд суурилсан орлогын төрөлжилт, байгалийн гаралтай үйлдвэрлэл гэх мэт үйл ажиллагаануудыг хамруулж ойлгоно. (Боварник, 2010).

Зөвлөмж боловсруулах

Бодлого, биелэлтийн хоорондын хамаарал, бодлого бүрийн биелэлтийн үр дүнг тооцох, шийдвэр гаргагчдыг БББ болон БКХО хувилбаруудаас зөвийг нь сонгоход туслах үүднээс тухайн мэдээллийг тэдэнд танилцуулдаг байх.

Зарим шийдвэр гаргагч ЗСШ-нд суурилсан ямар бодлогыг хэрэгжүүлэх талаар судлаачдын санал, тэдний шууд зөвлөмжийг сонсох хүсэлтэй байдаг. Шийдвэр гаргагчид аль нэг бодлогын хувилбарыг дэмжихээсээ өмнө тэдний давуу, сул талыг хэлэлцүүлэх сонирхолтой байдаг билээ. Зарим нь илүү бодит баримтад тулгуурласан хандлагыг илүүд үздэг.

Аль ч тохиолдолд бүхий л үзүүлэлтийн үр дүн, үйл ажиллагаа эрхлэгчдэд үзүүлэх нөлөөг судалж, харьцуулсан байдлыг шийдвэр гаргагчдад танилцуулах шаардлагатай. Аль нэг талыг баримтлахгүйгээр тэдэнд харьцуулсан судалгааг



танилцуулж, хамгийн гол нь хүчин зүйлс хийгээд аж ахуй эрхлэгчдийн харилцан хамаарлыг тодотгох нь зүйтэй юм (НҮБХХ ЗСШ)⁸.

Хязгаарлагдмал байдал

- Тус судалгаанд олон нийтэд нээлттэй байдаг техник эдийн засгийн болон экологийн мэдээллийг ашиглав. ГТБЦГ-ын талаарх судалгаа хийгдэж байгаагүй тул мэдээлэл маш хомс байлаа.
- Салбарын хандлагаар салбарын хүчин зүйлсийг тодорхой харуулах экосистемийн төрлүүдийн эдийн засгийн үнэ цэнэ, өргөн хүрээний системийг нэгтгээгүй.
- Үндэсний болон салбарын хэмжээний мэдээлэл байхгүйн улмаас БББ болон БКХО хувилбарын үр дүнг үнэлэх үзүүлэлтүүдийн сонголт хангалтгүй байв.
- Олдсон тохиромжтой мэдээллүүд нь хуучирсан, шинээр гарсан мэдээлэл маш бага байв.

Байгалийн аялал жуулчлал, усалгаатай газар тариалан, мал аж ахуй, ундны усны салбарыг дараах бүлгүүдэд үзүүлэв.

3.2. БАЙГАЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Энэхүү дэд бүлэгт ГТБЦГ-ын байгалийн аялал жуулчлалд оруулж буй хувь нэмэр хийгээд аялал жуулчлалын салбарын хөгжилд хэрхэн нөлөөлж буй талаар авч үзнэ. Энэхүү судалгаанд байгалийн аялал жуулчлал гэдэг үгийг “эко аялал жуулчлал”⁹ хэмээх нэр томъёотой адил утгаар хэрэглэх болно. Экотуризм нь байгалийн үзэсгэлэнт газруудтай шууд хамааралтай, эко аялал (байгалийн дурсгал, байгаль дээрх соёлын өвийг тайлбарлан таниулах), адал явдалт аялал(морь унах, уралдааны завь), төрөлжсөн аялал(загасчлах, ан агнуур), зэрлэг ан амьтан ажиглах аялал (байгалийн зэрлэг ан амьтан ажиглах), байгальд ээлтэй аялал жуулчлал (майхантай аялал)¹⁰ гэсэн олон төрөлтэйбөгөөдөөр төрлийн аялал жуулчлалтай хослон явагддаг.

⁸ НҮБХХЗорилтот салбарын шинжилгээ (2013)

⁹ Олон улсын эко аялал жуулчлалын нийгэмлэгээс (IES) эко аялал жуулчлал гэдэг нь “нутгийн хүмүүсийн сайн сайхан аж амьдралыг дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн хариуцлагатай аялал жуулчлалыг хэлнэ.” хэмээн тодорхойлжээ. “Байгалийн аялал жуулчлал” гэдгийг энгийнээр тайлбарлавал байгалийн үзэсгэлэнт газруудаар аялахыг хэлэх бөгөөд эко аялал жуулчлал гэдэг нь түүний нэг төрөл юм. Эко аялал жуулчлал нь олон улсын нийгэмлэгүүдэд амжилттай хэрэгжиж буй цогц зарчмаар хэрэгжиж байгаа бөгөөд судалгаа шинжилгээ ихээр хийж байна. Тэрхүү зарчимд суурилсан эко аялал жуулчлал нь аялал жуулчлалын хөгжилд ашиг тусаа өгч байна.

¹⁰ Байгалийн аялал жуулчлалын стратеги 2008-2012. Викториа мужийн захиргаа, Тогтвортой хөгжил, байгаль орчны хэлтэс, Викториа парк, Викториа аялал жуулчлалын агентлаг: tourismvictoria.com.au/naturebasedtourism.

ДХБ-ын тайлан (2010)-д аялал жуулчлалыг эдийн засаг, нийгмийн үзэгдэл юм хэмээн тодорхойлжээ. Аялал жуулчлал нь дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж буй салбаруудын нэг бөгөөд 2010 онд 6.4 хувь, 2011 онд 4.6 хувийн өсөлттэй гарчээ (ДХБ, 2012). Тус салбар нь дэлхийн ДНБ-ий 5 хувийг, аялал жуулчлалын салбар бага хөгжсөн орнуудад хамгийн багадаа ДНБ-ий 2 хувь, аялал жуулчлалыг эдийн засгийн гол салбараа болгосон орнуудад ДНБ-ий 10 гаруй хувийг бүрдүүлдэг байна (ДХБ, 2012).

ДХБ-ын судалгаа (2014)-гаар 2013 онд Ази, Номхон далайд 248 сая гадаадын жуулчид зорчсон нь дэлхийн нийт жуулчдын дөрөвний нэгтэй тэнцэж, өмнөх оноос 14 саяар өсчээ. Энэхүү 6 хувийн өсөлт нь дэлхийд хамгийн өндөр үзүүлэлт болов. Зүүн Өмнөд Ази энэхүү үзүүлэлтээрээ бүс нутагтаа төдийгүй дэлхийд тэргүүлж байна. Түүнчлэн Өмнөд Ази (+5%), Зүүн Хойд Ази (+4%) өндөр үзүүлэлттэй байгаа юм. ДХБ-ын төслийн хүрээнд Ази Номхон далайд зорчих жуулчдын тоо 2014 онд үргэлжлэн 5-6 хувиар өснө гэжээ.

Байгалийн аялал жуулчлал нь дэлхийн хэмжээнд жилдээ 10 –30 хувиар өсч, 1999 онд Дэлхийн Аялал Жуулчлалын Зөвлөлөөс олон улсын аялал жуулчлалын 10–15 хувийг байгалийн аялал жуулчлал эзэлж байна гэсэн судалгааг гаргажээ.

НҮБХХ (2010)-өөс одоогоор олон улсын жуулчдын 40 гаруй хувь нь байгалийн аялал жуулчлалыг сонгож байна.¹¹ Их Британи болон Герман улсад аялсан жуулчдын судалгаанаас хэд хэдэн зүйлийг онцолж болох юм. Үүнд: жуулчид аяллын маршрутаа сонгоход байгалийн сайхныг мэдрэх, орчин нөхцөл, амьдрал ахуйн чанар чухал байдаг гэжээ. Мөн аялахаасаа өмнө аяллын маршрут, тухайн байгалийн талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй болох сонирхолтой байдаг байна.

Хариуцлагатай аялал жуулчлалыг хөгжүүлэх төвөөс экотуризмын ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлжээ (2012):

- Конде Наст Аялагч сэтгүүлийн уншигчдаас авсан 2011 оны судалгаанд хамрагсадын 93% нь аялал жуулчлалын компаниуд байгаль орчныг хамгаалах хариуцлага хүлээдэг байх хэрэгтэй гэж үзсэн бол 58% нь зочид буудлууд байгаль орчныг хамгаалахад орон нутагтаа ямар нэгэн хураамж төлдөг байх нь зүйтэй хэмээн хариулжээ.
- 2011 онд нийт судалгаанд оролцогчдын 65% нь байгальд ээлтэй аялал жуулчлалыг сонгоно гэж хариулж байсан бол 2012оны

¹¹ ДХБ.

судалгаагаар 71, болсон нь “ногоон” аялал жуулчлалыг илүүд үзэх хандлага нэмэгдэж буйг харуулж байна.

Гадаадын болон дотоодын жуулчдын хувьд Монгол орны аялал жуулчлалын гол маршрутын нэг нь ГТБЦГ билээ. ГТБЦГ нь байгалийн хосгүй үзэсгэлэнт нутаг төдийгүй түүх, соёлын дурсгалт газар юм. Тус БЦГ нь боржин чулуун өвөрмөц тогтоцтой хад асга, өндөр уул нуруудын сайхнаараа алдартай бөгөөд гольф, явган аялал, завьтай аялал, морь унах, хаданд авирах зэрэгт тохиромжтой. Жуулчдын анхаарлыг татах бусад газруудад аялал жуулчлалын компаниас 80 км зайд орших Хагийн хар нуур, Естийн халуун рашааныг нэрлэж болно. Горхи-Тэрэлжийн БЦГ-т жуулчдад нээлттэй Буддын бясалгалын төв, Мэлхий хад, Өвгөн хад зэрэг байгалийн сонин тогтоцтой хад олон бий.

Сүүлийн жилүүдэд ГТБЦГ-ын ашиглалт ихсэж, 1996-2007 оны хооронд дотоодын жуулчдын тоо 25,000-аас 65,000 болж, гадаадын жуулчдын тоо 6,000-аас 30,000 хүртэл нэмэгджээ (ҮСХ, 2012). Дотоодын жуулчдын дийлэнх нь Улаанбаатар хотоос ирсэн аялагчид байдаг бол гадаадын жуулчдын хувьд голчлон Зүүн Азиас (ялангуяа Хятад, Солонгос) ирдэг байна. Явган аялагчид ихэвчлэн Баруун Европынхон байдаг. Зүүн Ази, Барууны аялагчид Горхи-Тэрэлжийн БЦГ-т аялах нь их байдаг.

Тус БЦГ болон түүний орчмын нутагт жуулчны баазыг ихээр байгуулж байна. 2003 онд дөнгөж 30 гэр бааз байсан бол өнөөдөр 150 гаруй газарт нэмэж гэр бааз байгуулах зөвшөөрөл олгожээ. Нийтдээ 180 жуулчны бааз 6,000 ортой үйл ажиллагаа явуулж байна. Жуулчдын байр сууцыг орчин үеийн стандартын барилга, ихэнхдээ гэр (орон нутгийн иргэд болон хоршооллын), модон байшин, рашаан сувилал, хүүхдийн зуслан зэрэгтөрөлтэй байна.

Ихэнх бааз (ойролцоогоор 80%) Тэрэлж болон Өвөр Горхи орчмоор байрлаж, жуулчид хүлээж авах байрны 75 хувийг гэр баазууд эзэлж байна. 6-аас 10-р сард жуулчид хамгийн их ирдэг (жилд ирэх жуулчдын 97%) бөгөөд оргил үедээ нийт жуулчид байр сууцны 80-90 хувьд байрладаг байна. Жуулчны баазууд ихэнх нь өвлийн улиралд үйл ажиллагаа явуулдаггүй. Цөөн тооны өвлийн дулаалгатай зочид буудал, гэр баазууд ажиллаж, жуулчид хүлээн авах нийт хүчин чадлын 30 хүрэхгүй хувиар ажилладаг байна.

ГТБЦГ-ын аялал жуулчлал 2007 оноос буурч эхэлсэн. Энэ нь аялал жуулчлалын тогтворгүй үйл ажиллагаа болон 2008 оны санхүүгийн хямралаас үүдэлтэй. Харин 2007-2012 оны хооронд эргэн өсч байгаа ч хурд нь удаан байна. Тиймээс ГТБЦГ-ын байгалийн аялал жуулчлал нь БББ хувилбараар явагдаж байна хэмээн үзэж болох юм. ГТБЦГ-ын аялал жуулчлалын салбарын БББ болон БКХО хувилбарын шинж чанарыг Хүснэгт 6-д үзүүлэв.

Хүснэгт 6. ГТБЦГ-ын Байгалийн аялал жуулчлалын салбарын шинж чанар (БББ/БКХО)

БББ хувилбар	БКХО хувилбар
<ul style="list-style-type: none"> • Аялал жуулчлалын тогтвортой бодлого байхгүйгээс жуулчдын тоо буурч байгаа; • Хязгаарлагдмал нөхцөл байдал: дотоодын галт тэрэг, автобусны зам хязгаарлагдмал, авто замын дэд бүтэц муу, тээврийн үйлчилгээ, аюулгүй байдал хангалтгүй, боловсон бие засах газар хомс. • Мэдээллийн төв, тараах материал байхгүй, онлайн мэдээлэл бага; • ТХГН-т нэвтрэх хураамж байхгүй, байгаа тохиолдолд маш хэмжээтэй; • Үйлчилгээний төрөлжилт, дэд бүтэц сул; замын тэмдэг, мэдээлэх самбар зэрэг хангалтгүй • Газар зохион байгуулалт муу: Улаанбаатар хот болон ГТБЦГ-ын хоорондын талбай. • Улаанбаатар хотын ойр орчимд агаарын бохирдол, хог хаягдал ихтэй • Аялал жуулчлалын үйлчилгээний салбарт ажлын байрны өсөлт бага (цалин бага) 	<ul style="list-style-type: none"> • Аялал жуулчлал, эдийн засгийн тогтвортой бодлого хэрэгжүүлэх замаар жуулчдын тоог нэмэгдүүлэх; • Автобус, нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах; • Хээр хооллох, боловсон бие засах газрыг байгуулж, жуулчны баазуудын ус, цахилгааны хангамжийг сайжруулан шүршүүр,; • Жуулчны мэдээллийн төвийг тохиромжтой байршилд байгуулах, англи монгол хэлээр онлайнаар мэдээлэл авах боломжтой болгох. • Жуулчдын аюулгүй байдлын хөтөлбөрийг бий болгох; • ТХГН-т нэврэх хураамжийг тогтоох, нэмэгдүүлэх; • Аялал жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний төрөлжилтийг сайжруулах: замын тэмдэг тэмдэглэгээ, мэдээлэх самбар, газрын зураг г.м • БАЖ-ын өргөжилтийн хүрээнд жижиг бизнес, ажлын байрыг нэмэгдүүлэх




2013 онд Монгол улс ДХБ-аас ДХБ-ын ST-EP сангийн аялал жуулчлалын чадамжийг дээшлүүлэх төслийн¹² хүрээнд аялал жуулчлалын салбарын хэтийн бодлогыг төлөвлөх зорилгоор аялал жуулчлалын салбарын өнөөгийн бодлогыг шинжлэн, үнэлэхэд шаардлагатай тусламжийг

¹² НҮБ-ын Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллагын Тогтвортой Аялал жуулчлал-Ядуурлыг бууруулах хөтөлбөр.

авсан байдаг. Энэ нь БКХО хувилбарт шилжих нэг алхам юм.

2007-2012 онд ГТБЦГ-т аялсан жуулчдын тоог Зураг 1-т үзүүлэв. Доорх зурагт үзүүлснээр жуулчдын тоо (дотоодын болон гадаадын) жилд дунджаар 4%-иар буурчээ. Хэдий тийм боловч ГТБЦГ-ын ЭСҮ нь БАЖ-д хувь нэмрээ оруулсан хэвээр байна.

График 1. ГТБЦГ-т ирсэн жуулчдын тоо (2007 – 2012).



Эх сурвалж: ҮСХ, 2013.


Монгол улс байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц боломж ихтэй, тус салбараас олох орлогыг нэмэгдүүлснээр улсын эдийн засагт жинтэй хувь нэмэр оруулах юм. Монгол улсын хувьд ТХГН болон байгалийн үзэсгэлэнт газруудаар аялагчид тээвэр, байр, хоол, сувинер гэх мэт зүйлст голчлон мөнгөө зарцуулдаг. Тиймээс жуулчдаас төрөл бүрийн салбарт орлого оруулж байдаг. Бусад салбарын адил аялал жуулчлал нь жуулчдад хүрч буй үйлчилгээгээр дамжуулан эдийн засгийн үйл ажиллагааны гинжин холбоог үүсгэдэг (жуулчид ихийг зарцуулах тусам ихийг олно.) төдийгүй тэдний нийлүүлэгч, нийлүүлэгчдийн нийлүүлэгч гэхчлэн эдийн засгийн эцэс төгсгөлгүй холбооны эцсийн хэрэглэгчид нь жуулчид болдог.

Үүнийг “олон талт үр ашиг” хэмээн нэрлэдэг (НҮБХХ, 2011)¹³.

Монголын эдийн засаг сэтгүүл (www.mongolian-economy.mn) (2013)-д нийтэлснээр 2011 онд чөлөөт цагаа өнгөрүүлэх эсвэл бизнесийн шугамаар ирсэн жуулчид аялалдаа дунджаар 581 ам.доллар болон 914 ам.доллар тус тус зарцуулжээ (2010 оны судалгаа). 2007-2012 оны хооронд ГТБЦГ-т чөлөөт цагаа өнгөрүүлэхээр ирсэн гадаадын жуулчдаас (122,218) нийт 70.9 сая ам.долларын орлого орсон байна. Цаашид хэдий хэмжээний орлого орох нь БББ хувилбарыг БКХО хувилбараар солих ЗГ-ын үүрэг амлалтын хэрэгжилтээс шалтгаална. График 2 болон 3-т БАЖ-ын салбарын боломжит ашиг, болзошгүй алдагдлыг харуулав.


¹³ НҮБХХ, 2011. Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн Гүржийн эдийн засгийн өсөлт, хүн амын сайн сайхан байдалд оруулж буй хувь нэмэр, үнэ цэнэ

График 2. ГТБЦГ-ын БАЖ-ын аялал жуулчлалын салбарын бууралт (2012-2025)



Эх сурвалж: ҮСХ 2013 болон судлаачдын тооцоо

График 3. Гадаадын жуулчдын зарцуулалт /БББ болон БКХО хувилбар/ (2012-2025)



Эх сурвалж: ҮСХ 2013 болон судлаачдын тооцоо



2007-2012 оны аялал жуулчлалын салбарын жилийн бууралт (4%)-ын хувиар 2012-2025 оныг тооцож үзвэл аялал жуулчлалаас олох орлого 2025 он гэхэд 10.9 сая ам.доллар болж буурна. Харин БКХО хувилбарт шилжсэнээр жил бүр 4%-иар өснө хэмээн үзвэл нийт орлого 2012 онд 10.9 сая ам.долларын орлого олж байсан бол 2015 онд 18.2 сая ам.доллар болж өсөх юм. БББ хувилбарыг БКХО хувилбараар сольсноор 2012-2015 онд 81.2 сая ам.долларын алдагдлаас урьдчилан сэргийлж чадна.

Монгол улс, ГТБЦГ, түүний ойр орчмын байгалийн аялал жуулчлалд ЭСҮ нь амин чухал боловч аялал жуулчлалын салбарт нөлөөлөгч цорын ганц хүчин зүйл биш билээ. Байгалийн аялал жуулчлалын бүтээмжийг нэмэгдүүлэх БКХО хувилбарт шилжих нь бодлогын томоохон шинэчлэл, нэлээд хэмжээний хөрөнгө шаардах юм.

БАЖ-ын салбарын орлогын хуваарилалтыг үнэлэх нь энэхүү судалгааны зорилго биш юм. Гэвч ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй БАЖ-ийн компаниудад жижиг гэр буудлууд, UB-2 зэрэг дунд хэмжээний зочид буудлууд, "Тэрэлж" таван одтой зочид буудал зэрэг өндөр зэрэглэлийн тансаг зочид буудлууд багтаж байна. Энэхүү зочид буудал нь дотоодын болон гадаадын өндөр зэрэглэлийн зочид төлөөлөгчдөд зориулагдсан билээ. Харамсалтай нь зочид буудлын салбараас олсон орлогоос ТХГ-дыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх аялал жуулчлалтай холбоотой санхүүгийн механизм байхгүй байна.

Олон улсын болон бүс нутгийн хэмжээний компаниуд гэр буудлыг олноор эзэмшдэг¹⁴. Үйлчилгээгээ тасралтгүй явуулах үүднээс хаа боломжтой газар гэр буудлуудыг орон нутгийн иргэдээс авч ажиллуулдаг нь орон нутгийн эдийн засагт шууд хувь нэмэр оруулж байна. Түүнчлэн гадаадын жуулчдын хэрэгцээнд тохирсон олон улсын стандартад нийцсэн үйлчилгээ үзүүлэх зорилгоор орон нутгийн иргэдэд сургалт зохион байгуулдаг. Мөн нутгийн соёл, заншлыг алдагдуулахгүйгээр хөдөө орон нутгийн хоршоодод аялал жуулчлалын салбарын хувь нэмрийг оруулах зорилготой Хоршоололд суурилсан аялал жуулчлалын сүлжээ гэх мэт ашгийн бус, төрийн бус байгууллагаас хоршооллын хөгжлийг дэмжин ажиллаж байна.

¹⁴ Монгол улсын аялал жуулчлалын тухай хуулиар аж ахуйн нэгж нь эрхлэх үйл ажиллагааны цар хүрээндээс хамааран тур-оператор /tour operator/ болон тур агент /tour agent/ гэсэн ерөнхий ангилалтай байх ба тур оператор нь үйл ажиллагааны онцлогоос хамааран олон улсын аялал жуулчлалын үйл ажиллагааг эрхлэх тур оператор /international tour operator/, гадаад орноос жуулчин хүлээн авах тур оператор /inbound tour operator/, гадаад орон руу жуулчин илгээх тур оператор /outbound tour operator/, дотоодын аялал жуулчлалын үйл ажиллагааг эрхлэх тур оператор /domestic tour operator/ гэсэн төрөлтэй байна. Олон улсын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх тур оператор /international tour operator/ нь гадаад орноос жуулчин хүлээн авах болон гадаад орон руу жуулчин илгээхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлэх ба дээрх чиглэлүүдээр дагнан 10-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан, аялал жуулчлалын байгууллагад мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан 4-өөс дээш боловсон хүчинтэй байна. Тур агентуудад одоогоор ангилал байхгүй. Монгол улсад өнөөдөр 33 өөр улсын хөрөнгө оруулалттай 452 тур оператор үйл ажиллагаа явуулж байна. Монгол улсад гадаад орноос жуулчин хүлээн авах тур операторуудыг НӨАТ-аас чөлөөлдөг.

3.3 УСАЛГААТАЙ ГАЗАР ТАРИАЛАН (УРГАЦ)

Хан Хэнтийн ДЦГ-тай зэрэгцээ орших ГТБЦГ-ын экосистемийн үйлчилгээ нь усалгаатай газар тариалангийн салбартай шууд хамааралтай юм. Монгол улсын хуулиар (Монгол Улсын Их Хурал, 1994)ТХГН-т аж ахуй эрхлэхийг хориглосон боловч хөрш зэргэлдээ орших бүс нутагт ГТБЦГ болон ХХДЦГ-ын экосистемийн үйлчилгээнээс ашиг хүртэж байна.

ГТБЦГ (мөн ХХДЦГ-тай холбогдоно)-аас усалгаатай газар тариаланд гурван төрлийн экосистемийн үйлчилгээг үзүүлж байна. Үүнд: цэвэр усны хангамж, тоос хүртээлт, бэлчээр. Газар тариалангийн салбарын экосистемийн менежментэд тогтвортой бус үйл ажиллагаа явуулж, хөрөнгө оруулалт хангалтгүйн улмаас усалгаатай газар тариалангийн салбар БББ хувилбараар хэрэгжиж байна. БББ болон БКХО хувилбарын шинж чанарыг Хүснэгт 7-д үзүүлэв.

Хүснэгт 7. Усалгаатай газар тариалангийн салбарын БББ болон БКХО хувилбарын шинж чанар

БББ хувилбар	БКХО хувилбар
<ul style="list-style-type: none"> Экосистемийн менежментийн бодлого байхгүй, үйлчилгээний хүртээмж хангалтгүй (бэлтгэгдээгүй эсвэл муу бэлтгэгдсэн ажилчид/фермерчид, мэдээллийн төвүүд, тараах материал хомс, агро-бизнесийн хөрөнгө оруулалт, хөгжлийн талаар зохицуулалт байхгүй). Газар тариалангийн бодлогын зохицуулалт, санхүүжилт муу. Усалгааны дэд бүтцийн төлөвлөлт, тогтвортой байдал сул хөгжсөн. Пестицид, химийн бордоог хэтрүүлэн хэрэглэдэг. Голын эрэг дагуу, бэлчээрийн ойр орчимд ой мод, ургамал багасах, бэлчээрийн систем муу. Усны бохирдол. Зохицуулалтгүй, сул зохион байгуулагдсан газар болон бүс нутаг /ялангуяа бэлчээр/ашиглалт. Зудын бэлтгэл муу. 	<ul style="list-style-type: none"> Аж ахуйн тохиромжтой бодлого, үйл ажиллагаа: экосистемийн менежментийн бодлого, үйлчилгээний үр дүнтэй, хүртээмжтэй байдал (бэлтгэгдсэн ажилчид, фермерчид, мэдээллийн төвүүд, тараах материал хангалттай, агро-бизнесийн хөрөнгө оруулалт, хөгжлийн зохицуулалт зөв хэрэгждэг). Зуданд бэлтгэх зэрэг газар тариалангийн тогтвортой бодлогод хөрөнгө оруулах. Усалгааны дэд бүтцийн тогтвортой, төлөвлөгдсөн байдал. Пестицид, химийн бордооны хэрэглээнд хяналт тавьж, хязгаарлах. Ой мод, ургамалжуулах стратеги боловсруулж, хэрэгжүүлэх. Усыг бохирдуулж буй хүчин зүйлсэд хяналт тавих, бууруулахад санхүүгийн арга хэрэгсэл ашиглах. Бэлчээр зэрэг газар, бүс нутаг ашиглалтыг сайтар зохион байгуулах.

ГТБЦГ-ын усалгаатай газар тариалангийн салбарын БББ болон БКХО хувилбар, түүнээс үүдэх ашиг, алдагдлыг үнэлэхдээ дараах үзүүлэлтүүдийг сонгон авлаа. Үүнд: бүтээгдэхүүний хэмжээ, зах зээлийн үнэ, ажлын байр. Дараах үнэлгээг МУТХГС-ний судалгааны мэдээнд үндэслэн тооцов.

Үндэсний Статистикийн Хорооны (2012)-ны судалгаагаар Төв аймаг болон Улаанбаатар хотод амьдарч буй олон иргэн газар тариалангийн компанид (3,525) ажиллаж, өрхийн аж ахуй эрхэлж байна. Үүнийг Хүснэгт 8-д үзүүлэв.

Хүснэгт 8. Газар тариалан эрхлэгч өрх гэр, компаниуд, Төв аймаг болон УБ хот (2002–2012)

Аймаг/хотын нэр	Сум/дүүргийн нэр	Газар тариалан эрхлэгч компани болон өрхийн тоо										
		2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Төв аймаг	Батсүмбэр	24	59	66	71	85	64	69	97	83	111	141
	Баяндэлгэр	11	12	14	19	15	12	19	16	16	99	29
	Эрдэнэ	24	90	99	99	49	99	48	49	45	61	78
Улаанбаатар хот	Баянзүрх	38	94	23	39	97	66	139	132	296	392	457
	Налайх	6	7	9	9	12	8	17	99	99	49	91
Нийт		101	157	145	163	255	185	354	354	474	631	733
Нийт												3,523

Эх сурвалж ҮСХ, 2013

Газар тариалангийн салбарт өрхийн хэрэгцээ болон арилжааны зорилгоор олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Судалгааны

зорилгод нийцүүлэн нийт газар тариалангийн бүтээгдэхүүн (өвс, малын тэжээл, үр тариа, рапсын үр, хүнсний ногоо, жимс)-ний цэвэр орлогыг




БББ болон БКХО хандлагыг гаргахад ашиглав. 2002-2012 оны хооронд ГТБЦГ орших сумдын ургацын нийт цэвэр орлого 16.9 тэрбум төгрөг

(12 сая ам.доллар)¹⁵ болжээ. Үүнийг График 4-т үзүүлэв. 2002-2012 онд бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлт 12.7% байсан байна.


15 2012 оны ам.долларын ханш, 1 ам.доллар=1359.24 төгрөг, Монгол банк (2012).

График 4. ГТБЦГ орших сумдын газар тариалангийн бүтээгдэхүүний цэвэр орлого(2002–2012)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2013); Судлаачдын тооцоо

График 5. Газар тариалангийн бүтээгдэхүүний БББ болон БКХО хувилбарын боломжит цэвэр орлого (2012–2035)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны мэдээнд үндэслэсэн судлаачдын тооцоо(2013)

Зах зээлийн нийт үнийг гурван үе шаттайгаар тооцсон. Нэгдүгээрт, газар тариалангийн бүтээгдэхүүний тоо хэмжээг харгалзах үнээр нь үржүүлэв; Хоёрдугаарт, нийт орлогыг тооцохдоо бүтээгдэхүүн тус бүрийн нийт үнийг хооронд нь нэмсэн. Усалгаатай газар тариалангийн салбарт дараах бүтээгдэхүүнийг хамруулав. Үүнд: өвс, малын тэжээл, үр тариа (улаан буудай, арвай, овъёос, хөх тариа), хүнсний ногоо (төмс, лууван, сонгино, байцаа, манжин, улаан манжин, өргөст хэмх), жимс (улаан лооль, тарвас, чацаргана).

Дээрх бүх орлого нь БББ хувилбараар явагдаж байна. Тиймээс урт хугацаанд тогтвортой байж чадахгүй. Цэвэр усны экосистемийн менежментийг сайжруулах ямар нэг арга хэмжээ аваагүй тохиолдолд орлого буурна. БББ болон БКХО хувилбарын төлвийг График 5-д үзүүлэв.

Жил бүрийн өсөлтийн хувь болох 12.7%-ийг БББ хувилбарын төлвийг гаргахад ашиглав. Ийнхүү өндөр өсөлттэй байвал газар тариалангийн бүтээгдэхүүний нийт орлого 2020 он гэхэд 4.9 тэрбум төгрөг болж өсөх юм. Гэвч БББ хувилбар үргэлжилвэл 2020 оноос эхлэн бага багаар (1-10%) буурч эхэлнэ. Энэ нь газар тариалангийн тогтворгүй үйл ажиллагаа, газар тариалангийн бодлогын санхүүжилт хангалтгүй, усалгааны дэд бүтэц хуучирсан, пестицид, химийн бордоог хэтрүүлэн хэрэглэх зэрэг нь дээрх үр дагаварт

хүргэнэ. Энэ хэвээр удаан үргэлжлэх тусам ирэх жилүүдэд БКХО хувилбарын тооцоолсон хэмжээнд хүрэхгүй байх магадлалтай.

БКХО хувилбарын дагуу жил бүрийн өсөлтийг 5%-иар тооцвол 2020 он гэхэд нийт ургацын цэвэр орлого 3,128 сая төгрөг болж, цаашид тогтворжих юм. Харин өнөөгийн БББ хувилбар үргэлжилвэл бүтээгдэхүүний хэмжээ тогтвортой бус хийгээд хөрсний эвдрэл, олон тэрбум төгрөгийн алдагдал учирч, зах зээлийн үнэ буурна.

Туул голын сав газрын усны менежментийн төлөвлөгөө (2012)-ний хүрээнд БКХО хувилбарт шилжээд байгаа ч усны эх үүсвэр, усны хагалбарыг хэрхэн хамгаалах гэх мэт экосистемийн менежмент, хэдий хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдах талаар тус менежментийн төлөвлөгөөнд тусгаагүй. Туул голын сав газрын усны менежментийн төлөвлөгөө нь 3,862 сая төгрөг¹⁶ (2.6 сая ам.доллар¹⁷)-ийн дэд бүтцийн ажил хийгдэж байна. Харин ГТБЦГ болон ХХДЦГ-ын усны эх үүсвэрийг хамгаалах үйл ажиллагааны менежментийн талаар тусгайлсан заалт байдаггүй. ТГСГУМТнэн тэргүүний зорилт, төсвийг Хүснэгт 9-д үзүүлэв.

¹⁶ Туул голын сав газрын усны менежментийн төлөвлөгөө -ТГСГУМТ (2012)

¹⁷ 2012 оны 12-р сарын төгрөгийн ам.доллартай харьцах ханш

Хүснэгт 9. ТГСГУМТ-нийэн тэргүүний зорилт ба төсөв.

Шийдвэрлэх асуудал	Шаардлагатай төсвийн дүн /сая.төг/
Шийдвэрлэх асуудал 1. Хүн амын усны хэрэглээ	2 573 116
Шийдвэрлэх асуудал 2. Үйлдвэрлэлд ашигладаг усны хэмжээ	25 926
Шийдвэрлэх асуудал 3. Газар тариалангийн салбарт ашиглах усны хэмжээ	166 617
Шийдвэрлэх асуудал 4. Байгаль орчинд шаардлагатай усны хэмжээ	977 939
Шийдвэрлэх асуудал 5. Усны хууль, эрх зүйн орчин, удирдлага	118 389
Шаардлагатай нийт хөрөнгө оруулалтын дүн	3 862 486

Эх сурвалж: ТГСГУМТ (2012-2021), 2012.

Бүтээмж буурснаар хүмүүсийн орлогод шууд нөлөө үзүүлнэ. ҮСХ (2013)-ны мэдээнд үндэслэсэн судлаачдын тооцоогоор газар тариалан эрхэлдэг өрхийн орлого 2002-2012 оны хооронд 45.9%-иар буюу 35.4 сая төгрөгөөс 1,718.76 сая төгрөг болж өсчээ; Тус хугацаанд нийтдээ 5,275 сая төгрөгийн орлого орсон байна. Энэ нь ГТБЦГ орших сум, дүүргүүдийн бага орлоготой өрхийн судалгаа юм. ТГСГУМТ (2012) Гадаргын болон гүний усны гол эх сурвалж болсон Туул голын ойр орчимд Монгол улсын нийт хүн амын 40% нь амьдарч байна. Жишээлбэл, Төв аймаг болон Улаанбаатар хотын холбогдох гурван сум, хоёр дүүргийн ядуурлын түвшин 2010 онд 29.9% байв. Тиймээс

ГТБЦГ-ын цэвэр усны экосистемийн үйлчилгээ нь газар тариалангийн бүтээгдэхүүнийг тогтвортой өсгөж, ядуурлыг бууруулахад чухал нөлөөтэй юм. Бүлэг 2-т үзүүлснээр нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал нөлөөтэй ГТБЦГ болон ХХДЦГ-ыг хамгаалахад хангалттай хөрөнгө оруулалт хийгдэхгүй байна.

Дээр дурдсан нийт орлогыг газар тариалангийн салбарт ажиллаж буй компани, өрх гэрүүдийн талаар гаргасан ҮСХ-ны тоо баримтад үндэслэн тооцов. Газар тариалангийн салбарт ажиллаж буй хүний тоог гаргахдаа нийт үйл ажиллагаа эрхлэгчдийн 95.2%-ийг өрх гэр, 4.8%-ийг



компани эзэлж байна (ҮСХ (2012), Улсын газар тариалангийн анхдугаар тооллого 2011). Өрх гэрт 1.5 хүн, компанид 4.4 хүн жилд дунджаар долоон сар ажилладаг. Үүний дараа 2011 онд тариалангийн салбарт ажиллаж байсан нийт хүний тоог тэдний сарын дундаж цалингаар үржүүлэв. (ҮСХ, 2012)¹⁸.

3.3 МАЛ АЖ АХУЙ

ГТБЦГ орших Батсүмбэр, Баяндэлгэр, Эрдэнэ сумын мал аж ахуйн салбарын тогтвортой байдалд

¹⁸ 2002-2012 оны хооронд газар тариалангийн аж ахуй эрхлэгч өрх гэр, компаниудын нийт тоо 3525 (169 компани (95.2%), 3355 өрх (4.8%)) байв. Өрх гэрийн аж ахуй эрхлэгчдийн тоо 5033, компанид ажиллагсдын тоо 744 байжээ.

бэлчээр чухал үүрэгтэй. Бэлчээргүйгээр мал аж ахуйн салбарыг төсөөлөх аргагүй юм. Ялангуяа гантай зун, зудтай өвөл бэлчээр маш чухал. Гэвч бэлчээрийн даац хэтэрснээс бэлчээрийн экосистем болон мал аж ахуйн салбарын бүтээмжид аюул учирч байна. Өнөөгийн байдлаар ГТБЦГ болон ХХДЦГ-т бэлчээрийн тогтвортой менежментийн хяналт, зохицуулалт аймаг, сумдын хэмжээнд байхгүй. Энэ нь экосистемд сөрөг нөлөө бүхий БББ хувилбарын илрэл юм.


Хүснэгт 10-т ГТБЦГ-ын мал аж ахуйн менежментийн БББ болон БКХО хувилбарын шинж чанарыг үзүүлэв.

Хүснэгт 10. ГТБЦГ-ын мал аж ахуйн менежментийн шинж чанар: БББ болон БКХО хувилбар	
<p>БББ хувилбар</p> <ul style="list-style-type: none"> • Бэлчээрийн даац хэтэрч, бэлчээрийн тогтвортой менежмент байхгүйгээс зэрлэг амьтад болон биологийн олон янз байдалд сөрөг нөлөө үзүүлж байна; • Мал бэлчээрлүүлэх уламжлалт менежмент (нүүдлийн аж ахуй) ундны ус, зарим газруудыг доройтуулж байна; • Үндэсний болон аймгийн хэмжээнд бэлчээрийн нөхцөл байдалд тавих хяналт, эргэн мэдээлэх цогц систем байхгүй; • Бэлчээрийн даацын талаар судалгаа хязгаарлагдмал, баттай эх сурвалжийн мэдээлэл хомс; • Мал тэжээх уламжлалт арга барил нь улирлаас хамааран бэлчээрийн даац хэтрүүлж, бэлчээрийн олон талт үр ашгийг сайжруулах стратегийг урамшуулж, дэмждэггүй. 	<p>БКХО хувилбар</p> <ul style="list-style-type: none"> • Зэрлэг амьтад, таван хошуу малын амьдрах орчин болсон бэлчээрийн нөөцийн менежментийг тогтвортой байлгах; • Уламжлалт нүүдэлчин зан заншлыг боловсронгуй болгож, усны эх сурвалжийн бохирдлыг багасгах; • Үндэсний болон аймгийн хэмжээний бэлчээрийн нөөцийн хяналт, эргэн мэдээлэх үр дүнтэй системийг бий болгох; • Тусгай хамгаалалттай газар нутгийн бэлчээрийн менежментийн судалгаа хийхэд хангалттай санхүүжилт хийх; • Бэлчээрийн бодлого, улирлын чанартай бэлчээрийн даац хэтрэхээс сэргийлэх бэлчээрийн шинэ стратегийг хэрэгжүүлж, хяналт тавих; Олон талт үр ашгийг нэмэгдүүлэх бэлчээрийн стратегийг баталж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

ГТБЦГ орших сумдын мал аж ахуйн үйл ажиллагаагаар (ж.нь., хонь, үхэр морь) нь олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Энэхүү судалгааны зорилгод нийцүүлэн мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүний зах зээлийн үнийг БББ болон БКХО хувилбарын төлвийг

гаргахад ашиглав. ГТБЦГ орших сумдын мал аж ахуйн бүтээгдэхүүний нийт орлого 2002-2012 оны хооронд 60,9 тэрбум төгрөг (43.4 сая ам.доллар) болжээ. Үүнийг График 6-д харуулав. 2002-2012 оны хооронд нийт бүтээгдэхүүний хэмжээ жил бүр 20%-иар өссөн байна.

График 6. ГТБЦГ орших сумдын мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн цэвэр ашиг (2002-2012)



Эх сурвалж: ҮСХ, 2013

Одоогоор ГТБЦГ-т бэлчээрийн тогтвортой менежмент байхгүй, бэлчээрийн даац хэтрүүлэн, хөрс элэгдэж байгаагаас усны эх үүсвэр, бэлчээрийн экосистем доройтож байна.

БББ хувилбар экосистемд нөлөөлж, бүтээгдэхүүний гарцад мөн сөргөөр нөлөөлж байна. Хотжилт дагасан даяарчлалын үед эдийн засгийн байдал хүнд болж, мал хувьчлал явуулсан зэрэг нь хүмүүс хөдөө мал хариулж амьдрах гол шалтгаан болсон. Үүний дүнд Монгол улсын хэмжээнд сүүлийн арваад жилд малчдын тоо гурав дахин буюу 450,000 болтлоо өсч, малын тоо толгой 30 хувиар нэмэгдлээ. Энэ нь бэлчээрийн даац хэтрэх асуудлыг дагуулж байна. Бүсийн мал аж ахуй, газар тариалангийн товчооны 2010 оны судалгаагаар Өвөр Монголын 88 сая га бэлчээрийн талбайн 66 хувь нь малчдын эзэмшилд шилжжээ.


Зао (2014) судлаачийн үзэж буйгаар Өвөр Монголын нэг га талбай бэлчээрт 4.5 хонь

бэлчих зарчмыг баримталж байгаач сүүлийн жилүүдэд энэ тоо 5 болж өссөн нь бэлчээрийн даац хэтэрсэнээр хонины амьд жин эрс буурч, зах зээлийн үнийг тогтвортой байлгахад хонины махны хэмжээг бууруулахгүйн тулд илүү олон хонь өсгөх шаардлага бий болсон. Энэ нь БББ хувилбарын тод жишээ юм.

БББ хувилбар нь эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой байдлыг бууруулж байдаг. Жишээлбэл, 2012 оны нийт цэвэр орлого 13.2 тэрбум төгрөг байсан бөгөөд жилийн дундаж өсөлт 20% (жилийн дундаж өсөлтийн хувь 2002-2012) байв. Цаашид энэ байдлаар зах зээлийн нийт үнэ 81.7 тэрбум төгрөг (58.3 сая ам.доллар)-т хүрэх боломжтой. Гэвч энэхүү орлого нь байгаль орчны асар их хохирлыг дагуулах юм. Энэхүү судалгаанд статистикийн зарим мэдээллийг ашигласан боловч ГТБЦГ-ын мал аж ахуйн салбарын чанарын болон тоон судалгаа байхгүй байна. БББ болон БКХО хувилбарын хандлагыг График 7-д үзүүлэв.



График 7. БББ болон БКХО хувилбарын мал аж ахуйн салбарын цэвэр орлогын төлөв (2012–2040)



Эх сурвалж: Албан мэдээнд үнэдслэсэн судлаачдын тооцоо (2013).

БББ хувилбараар 2020 оноос эхлэн орлого нь аажмаар (5%) буурч эхэлнэ. Энэхүү бууралтын хувийг ашиглан мал аж ахуйн салбарын ирэх жилүүдийн БКХО хувилбарыг хэрэгжүүлээгүйгээс үүдэх алдагдлыг тооцов. БКХО хувилбараар нийт ашиг 2030 он гэхэд 48.3 тэрбум төгрөгт хүрч тогтворжино. БКХО хувилбарыг хэрэгжүүлэхэд бодлогын шинэчлэл, хангалттай хөрөнгө оруулалт шаардлагатай. БББ хувилбар нь олон тэрбум төгрөгийн алдагдалд хүргэх юм.

Туул голын сав газрын усны менежментийн төлөвлөгөө (2012) БКХО хувилбарт шилжиж эхэлсэн. Энэ нь мал аж ахуйн салбарын менежментийг сайжруулахад чухал нөлөө үзүүлж байна. Гэвч ГТБЦГ болон ХХДЦГ-ын үйл ажиллагааны менежментийг сайжруулах усны эх үүсвэр, бусад нөөцийг хамгаалах тусгайлсан зүйл заалт байхгүй байна.

Мал аж ахуйн салбарын бүтээмж буурснаар хүмүүсийн орлогод шууд нөлөөлдөг. ҮСХ (2012)-ны мэдээнд суурилсан судлаачдын тооцоогоор мал аж ахуй эрхэлж буй өрхийн жилийн дундаж орлогын өсөлт 2002-2012 оны хооронд 26.5%-тай, 971 сая төгрөг байснаас 10,139 сая төгрөг болтлоо өсчээ. Энэ хугацаанд нийтдээ 52,153 сая төгрөг олжээ.

Нийт цэвэр ашгийг 3 үе шаттайгаар тооцов.

Нэгдүгээрт мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүний нийт хэмжээг харгалзах зах зээлийн үнээр үржүүлэв. Хоёрдугаарт бүтээгдэхүүн тус бүрийн үржүүлсэн үнийг хооронд нь нэмсэн. Хамгийн сүүлд мал аж ахуйн бүтээгдэхүүний нийт үнийг түүний зардлын хувиар үржүүлэн хассан болно. Газар тариалангийн улсын анхны тооллогоор 2011 онд мал аж ахуйн салбарын нийт орлого дахь зардлын хувийг тооцжээ. Статистикийн эмхэтгэлд зааснаар мал аж ахуйн салбарын нийт орлогод эзлэх зардлын хувь 2006 онд 72.5% байсан бол 2010 онд 58.9% болжээ. Энэхүү тоо баримтад үндэслэн бусад жилүүдийн орлогыг тооцов. For livestock sector following products are accounted for total value estimation: Таван хошуу малын мах, сүү, арьс шир, ноолуур, ноос гэсэн таван төрлийн бүтээгдэхүүнийг мал аж ахуйн салбарын нийт орлогыг тооцоход хамруулав.

3.5. УНДНЫ УС

ГТБЦГ-тай хамгийн ойр оршиж, цэвэр усны экосистемийн үйлчилгээг хамгийн ихээр хүртдэг нь нийслэл Улаанбаатар хотынхон юм. Туул гол нь ГТБЦГ болон Хэнтийн нуруунаас эх авч Улаанбаатар хотын дундуур дайран 704 км урсаад Сэлэнгэ мөрөнд цутгадаг. Ойролцоогоор 49.84 км² талбай гээлэх бөгөөд Орхон голтой нийлж,

Сэлэнгэ мөрөнд цутгадаг байна. Сэлэнгэ мөрөн нь Байгаль нуурт цутгадаг.

Туул голын байршил



Эх сурвалж: Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар(2014)

Хөдөө, орон нутгаас шилжин ирэгсэд нэмэгдэж, хотын захад гэр барин суурьшиж байгаа нь Улаанбаатар хотын хүн амын ундны усны хэрэглээнд шууд нөлөөлж байна. Гэр хороолол төлөвлөгдөөгүй хэмжээнд нэмэгдсэнээр агаарын бохирдол (нүүрс түлэх), усны бохирдол, усны хангамж хомсдох зэрэг байгаль орчны асуудлуудыг дагуулж байгаа юм. Усны хэрэгцээ нэмэгдэх нь усны хангамжийн экосистемд сөргөөр нөлөөлдөг.

Туул голын орчмоор 30-70 метрийн гүний 150 гаруй худаг, өдөрт 170,000 м³ гүний усаар хангадаг. Ус сувгийн удирдах газар (УСУГ) Улаанбаатар хотыг усаар хангах үүрэгтэй. УСУГ 177,500 м³/хоног хүчин чадалтай, /нийт хүчин чадал нь 230,000 м³/хоног ч нийт хүчин чадлаараа ажилладаггүй/. Хот төлөвлөлтөөр хүн амын өсөлтөөс шалтгаалан 240,000 м³/хоног нэмэлт усны хэрэгцээ бий болно хэмээн тооцоолсон. Улаанбаатар хотод усны хомсдол өдөр тутмын асуудал болох хандлагатай байна. CSC судалгаагаар усны нийт хэрэгцээ 2030 он гэхэд 510,700 м³/хоног болох аж.

Хүснэгт 11 Ундны усны салбарын БББ болон БКХО хувилбарын өнөөгийн шинж чанар

Хүснэгт 11. ГТБЦГ орших сумдын усны менежментийн БББ болон БКХО хувилбарын шинж чанар	
<p>БББ хувилбар</p> <ul style="list-style-type: none"> • Усны эх үүсвэрийн тогтвортой бус менежмент • Хот суурин газрын усны хэрэгцээ төлөвлөөгүй ихээр өсч байгаа • Гэр хороолол, хөдөө орон нутгийн усны хангамж хязгаарлагдмал • Усны бохирдол, цэвэршүүлэх төхөөрөмж дутагдалтай • Ус цэвэршүүлэх менежмент сул байгаагаас үүдэн усаар дамжих халдварт өвчин нэмэгдсэн • Засгийн газрын хөрөнгө оруулалт хангалтгүй, засгийн газраас тогтоосон усны үнэ хямд байгаагаас шалтгаалан усны хангамжийн систем доройтож байна. 	<p>БКХО хувилбар</p> <ul style="list-style-type: none"> • ТХГН-ийн усны эх үүсвэрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх • Хот суурин газрын усны хангамжийг төлөвлөж, тогтвортой байлгах • Гэр хороолол, хөдөө орон нутагт усны найдвартай эх үүсвэрийг бий болгох • Ус цэвэршүүлэх төхөөрөмжийг сайжруулах • Ус цэвэршүүлэх менежментийг сайжруулах замаар усаар дамжих халдварт өвчнийг багасгах • Усны хангамжийн дэд бүтэц, усны эх үүсвэрийг тогтворжуулах, усны хангамж болон цэвэршүүлэх зардлыг нөхөх үүднээс усны үнийг хатуу тогтоохгүй байх

Монгол улсад усны үнэ экологийн болон эдийн засгийн үндсэн өртгөөсөө доогуур, Засгийн шазраас ихээхэн татаас олгодог. Энэхүү бодлого нь хэрэглэгчдийг хямд үнэтэй усыг замбараагүй хэрэглэхэд хүргэж байна. Жишээлбэл, Усны хангамж, шугам сүлжээний удирдлагаас хийсэн тооцоогоор 2012 онд гэр хорооллын айл өрхийн худалдан авсан нийт усны хэмжээ 681,800 м³ бөгөөд нэг м³ усны үнэ 5,294.8 төгрөг (3.9 ам.доллар) байжээ. Гэвч нэг м³ усыг 911.6 төгрөг (0.671 ам.доллар)-өөр зарсан байна. Мөн ийм илтгэлд нэг м³ усны үнэ 6,204.2 төгрөг (4.56 ам.доллар) байхад гэр хорооллын айл өрхүүдэд зарагдаж буй үнэ 909.1 төгрөг (0.669 ам.доллар) байжээ. Монгол улсад усны үнэ улс төрийн хүчин

зүйл болдог бөгөөд засгийн газар, ус хангамжийн үйлдвэрүүд үүнээс ихээхэн алдагдал хүлээдэг. Усны үнийн энэхүү байдал нь БББ хувилбарыг илтгэж байна. .

ҮСХ (2012)-ны судалгаагаар гэр хороолол болон төвийн усны шугамд холбогдоогүй газар амьдардаг хүн өдөрт дунджаар 6.6 литр ус хэрэглэдэг. Хот суурин газарт төвийн усны шугамд холбогдсон байр, орон сууцанд амьдарч буй хүн өдөрт дунджаар 239.05 литр ус хэрэглэдэг ажээ.

ГТБЦГ-ын орших Төв аймгийн 3 сум, Улаанбаатар хотын 2 дүүрэгт нэг хүн өдөрт дунджаар 6.63 литр, жилдээ 2.42 м³ ус хэрэглэдэг ажээ.



Усны үнийн талаарх мэдээллийг олон эх сурвалжаас авсан. Жишээ нь: Эмертон, (2009) судалгаанд Улаанбаатар хотын иргэдийн ундны усанд төлөх боломжтой үнэ 1.36 төгрөг (0.001 ам.доллар) гэжээ. Түүнчлэн Засгийн газрын (2011) баталсан усны экологийн болон эдийн засгийн тогтоол. Тогтоолын нэгдүгээр хавсралтад газар доорх усны нэг литрийн үнэ 0.944 төгрөг (0.0007 ам.доллар), гадаргын ус 1.06 төгрөг (0.0008 ам.доллар)¹⁹


¹⁹ Монгол Улсын Засгийн Газрын тогтоолын Хавсралт 11-т нэг метр куб усны үнэ **2,651 төгрөг (1.95 ам.доллар)**, үүнийг хүн амын усны хэрэглээний эквивалент **0.4**-өөр үржүүлснийг ЗГ-ын ижил тогтоолын Хавсралт 4-т 2013 онд шинэчлэн баталжээ. Үүний дараа метр куб гэсэн хэмжээсийг литрт шилжүүлсэн. Газар доорх усны үнийг тооцоходоо мөн ижил аргыг хэрэглэсэн бөгөөд гагцхүү усны эквивалентыг **0.1**-ээр тооцож, нэг метр куб усны үнэ 9,440 төгрөг буюу 6.95ам.доллар (Монгол Улсын Засгийн Газар, 2011) болж байна.

хэмээн заажээ.

Ундны усны эдийн засгийн нийт үнийг тооцоходоо График 8-д үзүүлснээр дараах зүйлст анхаарав. Үүнд:

- Усны дундаж үнийг ЗГ-ын усны үнийн талаарх тогтоолын дагуу тооцсон. (1,789 төгрөг буюу 1.36 ам.доллар)(Дэлгэрэнгүйг салбарын судалгааны илтгэлээс үзнэ үү.)
- Улаанбаатар хотын 2 дүүрэг, Төв аймгийн 3 суманд хэрэглэсэн усны хэмжээний нийлбэр.

График 8. ГТБЦГ орших сум, дүүргийн ундны усны нийт үнэ



Эх сурвалж: ҮСХ, 2012.

Дээрх графикт үзүүлснээр усны хангамж багасч байгаатай холбоотойгоор ундны усны эдийн засгийн үнэ өсч байна. Гэвч дээрх орлогоос цэвэр усны экосистемийн менежментийг сайжруулахад хөрөнгө оруулахгүй байгаа нь БББ хувилбарын тод жишээ юм. Ялангуяа усны эх үүсвэрийг урт хугацаанд хамгаалах шаардлагатай. Туул Голын Сав Газрын Усны Менежментийн Төлөвлөгөөгөөр, Туул голын экосистем сайтар хамгаалагдсан ч хөрсний элэгдэл, бэлчээрийн даац хэтэрснээс үүдэн бохирдол нь илт мэдэгдэх болсон гэжээ. Тиймээс цэвэр усны нөөцийн өнөөгийн байдал БББ хувилбараар явагдаж байна.

БББ болон БКХО хувилбарын хандлагыг График 9-д үзүүлэв. БББ хувилбар үргэлжилвэл өнөөгийн усны хангамж нэмэгдэхгүй, эрэлт өснө. Тиймээс усны экосистемээс олж бий орлого аажмаар буурах юм. БКХО хувилбараар усны хангамжийн менежментэд зохих хөрөнгө оруулалтыг хийснээр усны хангамж тогтвортой байж чадна.

2002-2012 оны орлогын дундаж өсөлт 5.5% байсан ба 2025 он хүртэл энэ хэвээр байна хэмээн үзэв. Харин 2035 оноос уснаас олох орлого 2012 оны хэмжээнд хүртэл буурна. Ингэснээр хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөнөөс гадна эдийн засгийн хувьд ихээхэн хохиролтой.

График 9. Ундны усны БББ болон БКХО хувилбарын зах зээлийн үнийн хандлага (2012–2035)



Эх сурвалж: ҮСХ-ны мэдээнд үндэслэсэн судлаачдын тооцоо, 2013.

БКХО хувилбараар зах зээлийн орлого 5.5%-иар үргэлжлэн өснө гэвэл 2035 он гэхэд 185.1 тэрбум төгрөгт хүрнэ. Харин БББ хувилбараар усны эх үүсвэрийг хамгаалах, хангамжийн менежментэд хөрөнгө оруулалт хангалтгүй хэвээр байвал 872.2 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж болзошгүй юм. БББ хувилбарыг БКХО хувилбараар сольсноор энэхүү алдагдлаас урьдчилан сэргийлэх боломжтой.

Боломжит ашиг, болзошгүй алдагдлыг урьдчилан таамагласан болно. Гэвч усны үнэ, түүнээс олох орлого нь усны хангамжийн тогтвортой байдалд чухал хүчин зүйл билээ.

Усны менежмент, үнэ тариф, газар тариалан, ой модтой холбоотой бодлогыг шинэчилснээр Улаанбаатар хот, түүний эргэн тойрны усны өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангаж чадна.



4. ДҮГНЭЛТ, БОДЛОГЫН САНАЛ ЗӨВЛӨМЖ

4.1 ДҮГНЭЛТ

Судалгаанд ашиглах мэдээллийн олдоц хязгаарлагдмал байсан хэдий ч ГТБЦГ-ын ЭСҮ нь бүс нутгийн эдийн засагт асар их хувь нэмэр оруулдаг болохыг илтгэх нотолгоо хангалттай байна.

Гэвч нөөц улам бүр шавхагдаж буй нь аялал жуулчлал, мал аж ахуй, усалгаатай газар тариалангийн салбарын БББ хандлагыг нэн даруй өөрчлөх шаардлагатайг харуулж байгаа бөгөөд БББ хувилбарын экосистем болон салбарын эдийн засаг дахь сөрөг нөлөө улам бүр ил болж байна. Харин БКХО хувилбарт шилжсэнээр бүтээмж тогтворжиж, олон тэрбум төгрөгийн алдагдлаас урьдчилан сэргийлэх боломжтой. Тиймээс Монгол улсын эдийн засгийг хөгжүүлэхэд экосистемийн удирдлага, зохион байгуулалтын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, экосистемийн менежмент, хөрөнгө оруулалтын бодлогыг шинэчлэх зайлшгүй шаардлагатай.

Энэхүү судалгаанд сонгон авсан салбаруудын хөгжлийн хандлага өдийг хүртэл БББ хувилбараар явж ирсэн хэмээн дүгнэсэн ба БКХО хувилбарт шилжсэнээр эдийн засгийн ашиг дунд болон урт хугацаанд тогтворжих юм. Тухайлбал:

- Байгалийн аялал жуулчлалаас жилд олох орлого эдийн засагт чухал үүрэгтэй боловч экосистемийн менежментийг хамруулсан аялал жуулчлалын тогтвортой стратеги байхгүйгээс өндөр эрсдэлтэй салбаруудын нэг болоод байна. Түүнчлэн байгалийн тогтвортой аялал жуулчлал нь мал аж ахуйн салбарын сөрөг нөлөөг бууруулах ач холбогдолтой.
- Бэлчээрийн экосистем нь ГТБЦГ болон түүний ойр орчмын нутгийн мал аж ахуйн салбар, сүү сүүн бүтээгдэхүүнийг тогтвортой байлгахад амин чухал нөлөөтэй. ГТБЦГ нь бусад ТХГ-дын адил өвлийн хахир хүйтэнд мал сүргийг онд оруулах гол хүчин зүйл болох бэлчээрийн нөөц газар болдог. ГТБЦГ-ын бэлчээрийн нөөц нь бүс нутгийнхаа нийгэм, эдийн засгийн хөгжилд

жинтэй хувь нэмэр оруулж байдаг. ГТБЦГ болон түүний ойр орчмын нутгийн мал аж ахуй хот, хөдөөгийн айл өрхүүдийн амьжиргааны гол эх үүсвэр болж байна. Гэвч ГТБЦГ-т хөрсний элэгдэл, бэлчээрийн даац хэтрэх гэхчлэн байгаль орчны доройтлыг дагуулж байдаг. Цаашид доройтлын хэмжээ, түүний эдийн засгийн алдагдлыг судлах шаардлагатай.

- ГТБЦГ-аас эхтэй ундны ус нь хүн амын аж амьдралыг тэтгэж байна. Монгол улсын нийт хүн амын 40 орчим хувийг эзлэх Улаанбаатар хотын оршин суугчид тус бүс нутагт амьдардаг. Түүнчлэн үйлдвэр, газар тариалан, мал аж ахуйн хөгжилд чухал нөлөөтэй.

ЗСШ-ээр зэрлэг амьтад, цэвэр ус, бэлчээр зэрэг амин чухал экосистемийн үйлчилгээний оролцоотой салбарын бүтээгдэхүүний үнэ цэнийг тооцов. Гэвч энэхүү судалгаанд үзүүлсэн ГТБЦГ-ын эдийн засгийн өнөөгийн орлогыг тогтвортой байлгахад БКХО хувилбарт шилжих шаардлагатай.

Түүнчлэн салбар тус бүрийн судалгаанаас үзэхэд (Их Нартын БНГ болон Орхоны хөндийн БЦГ), энэхүү судалгаанд хийсэн тооцооллыг нарийвчлан, иж бүрэн судалгаа хийвэл нийт ашиг одоогийн тооцоолсноос олон дахин нэмэгдэх боломжтой.

Эдийн засгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын бодлого (ж.нь., ГТБЦГ-ын үндсэн үйл ажиллагаанд шаардлагатай нэмэлт санхүүжилт) (одоогоор 20 хүрэхгүй хувьтай байна.), корпорацийн бизнесийн төлөвлөгөө, төрөөс оруулах хөрөнгө оруулалтын бодлого экосистемийн үйлчилгээнд ихээр нөлөөлдөг.

4.2. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах санал, зөвлөмжийг гаргалаа.

- ГТБЦГ болон түүний ойр орчмын экосистемийн менежментийг сайжруулахад тулгарч буй бодлогын саад, гажуудалд нарийвчилсан үнэлгээ

хийх; үнэлгээний дүнд үндэслэн дараах голлох салбаруудын байгалийн нөөцийн тогтвортой менежментийг боловсруулахад БОНХАЖЯ-ны дэмжлэгтэйгээр ГТБЦГ-ын сум, нийслэл хот, дүүргүүдийн удирдлага, тур оператор, орон нутгийн малчдын хамтын ажиллагааг дээшлүүлэх. Салбаруудад нэн тэргүүнд авах шаардлагатай арга хэмжээг доор тусгав. Үүнд:

Байгалийн аялал жуулчлал:

- Дараах зүйлсийг хэрэгжүүлэхэд Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлж, нэвтрүүлэх: жуулчдын тоог нэмэгдүүлэх; тээвэр (төрийн болон хувийн) дэд бүтцийг хөгжүүлэх, жуулчдын аюулгүй байдлын хөтөлбөр боловсруулах, ТХГН-т нэвтрэн орох хураамжийг тогтоох.
- Байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар ажлын байр шинээр бий болгох, жижиг бизнесийг хөгжүүлэх.
- Аялал жуулчлалын салбарын экосистемийн менежменттэй холбоотой хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хөгжүүлэх, төрийн хөрөнгө оруулалтыг судлах; Хөнгөлөлттэй зээл, биологийн олон янз байдал экологид ээлтэй байгууллагуудтай хамтран хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хөгжүүлэхэд тур оператор, үйлдвэрлэлийн танхим, санхүүгийн салбарынхантай хамтран ажиллах.
- ГТБЦГ-ын веб хуудас үүсгэж, ТХГН-ийн санхүүгийн болон эдийн засгийн мэдээлэл, ТХГН-ийн сүлжээний харилцан хамаарлын мэдээллийг англи, монгол хэлээр оруулах.
- Экосистем, биологийн төрөл зүйлийн талаар боловсролын хөтөлбөрийг сайжруулан нэвтрүүлэхэд орон нутгийн сургууль, удирдлагууд хамтран ажиллах.
- Монгол улсын биологийн олон янз байдлын үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөнд аялал жуулчлалын тогтвортой хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хамруулах.

Усалгаатай газар тариалан:

- Газар тариалангийн оновчтой бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх: экосистемийн менежментийн бодлого,

цэвэр усны экосистемийн менежмент дэх үр ашигтай үйлчилгээг өргөжүүлэх (бэлтгэгдсэн ажилчин, тариаланчид, мэдээллийн төвүүд, тараах материал, салбарын бодлого зохицуулалт, ногоон агро-бизнесийн хөрөнгө оруулалт, хөгжил).

- Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр газар тариалангийн тогтвортой бодлогыг дэмжих.
- Усалгааны дэд бүтцийн менежментэд цэвэр усны экосистемийн менежментийг тусгах.
- Пестицид болон химийн бордооны хэрэглээг хязгаарлахад газар тариалангийн тогтвортой бодлогод санхүүгийн арга хэрэгслээр дэмжлэг үзүүлэх.
- Ой модны тогтвортой стратегид цэвэр усны экосистемийн менежментийг хамруулах
- Пестицид, химийн бордоотой холбоотой усны бохирдлыг бууруулан, хяналт тавихад санхүүгийн арга хэрэгсэл ашиглах.
- Газар ашиглалт, бүс нутаг хуваарилалтанд экосистемийн менежментийн зарчмыг нэвтрүүлэн хөгжүүлэх.
- Газар тариалангийн салбарын экосистемийн менежменттэй холбогдолтой хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хөгжүүлэхэд төрийн хөрөнгө оруулалтын тогтолцоог үнэлэх.
- Монгол улсын биологийн төрөл зүйлийн үндэсний стратегид газар тариалангийн салбарын тогтвортой хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг тусгах.

Бэлчээр (мал аж ахуй)

- Дараах зүйлсийг нэмэгдүүлэх\бууруулах үүднээс газар тариалангийн салбарын бодлогод бэлчээрийн тогтвортой менежментийн зарчмыг боловсруулан, нэвтрүүлэх.
- Бэлчээрийн нөхцөл байдлыг хянаж шалгах параметруудийг бий болгох;
- ТХГ-ын бэлчээрийн менежментийг хөгжүүлэх судалгаанд хөрөнгө оруулах;
- Бэлчээрийн олон талт үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой стратегийг батлах, санхүүгийн арга хэрэгслээр



идэвхжүүлэхэд төрийн болон хувийн хэвшлүүд хамтран ажиллах.

- Монгол улсын биологийн төрөл зүйлийн үндэсний стратегийн үйл ажиллагааны хөтөлбөрт бэлчээрийн тогтвортой хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг тусгах.

Ундны усны хангамж:

- Үндсэн бодлогод цэвэр усны экосистемийн менежментийн зарчмыг нэвтрүүлэн хөгжүүлэх: усны нөөц, давхарга, усны хангамж, хамгаалалтын хил зааг, үнэ тариф (дотоодын, арилжааны, үйлдвэрийн, усалгааны) болон хог хаягдлын менежмент.

- Цэвэр усны экосистемийн менежментийн хэрэгжилтийг хянаж, мэдээлж байх.
- Монгол улсын Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, Уур амьсгалын өөрчлөлтийн стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд цэвэр усны экосистемийн менежментийн тогтвортой хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг (төрийн болон хувийн) тусгах.
- Туулголын сав газрын усны менежментийн төлөвлөгөөний шинэ хувилбарт дүн шинжилгээ хийх(бүх салбарт).

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- О.Алтансүх, Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг орших сумдын газрын зураг. Улаанбаатар хот, (2014)
- Б.Баранчулуун, Т.Лувсанболд, С.Нандинцэцэг, К.Кэнжегүл, Усалгаатай газар тариалангийн хөгжил. Газар тариалан, хөнгөн үйлдвэрийн яам: Улаанбаатар хот, (2011)
- Д.Баасандорж, С.Синг, Монгол улсын хөдөө орон нутгийн усны хангамж, цэвэршүүлэлт. Улаанбаатар хот, (2009) http://www.unicef.org/eapro/6_Mongolia_Rural_water_supply_and_sanitation.pdf
- П.Батимаа, Б.Мягмаржав, Н.Батнасан, Н.Жадамбаа, П.Хишигсүрэн, Монгол улсын уур амьсгалын өөрчлөлт дэх хот суурин газрын усны хангамжийн хурцадмал байдал. Улаанбаатар хот, (2011)
- К.Дидиер, О.Лхамжав, Монгол орны зүүн бүсийн тал нутаг дахь эрчимжсэн газар тариалангийн нөөц боломж: Түүх, Өнөөгийн байдал, Засгийн газрын төлөвлөлт, Биологийн төрөл зүйлийн нөлөө. USAID. (2009)
- Л.Эмертон, Н.Эрдэнэсайхан, Д.В.Бастиаан, Д.Цогоо, Л.Жанчивдорж, П.Сувд, А.Энхбаатар, Монгол улс-Туул голын экосистемийн эдийн засгийн үнэ цэнэ. Тогтвортой хөгжил. (хуу. 1–108). Вашингтон хот, (2009)
- Монгол Улсын Засгийн Газар. “АТРЫН ГУРАВ ДАХЬ АЯН”-ТАРИАЛАНГИЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (2008). Монгол улс.
- Монгол Улсын Засгийн Газар, Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол № 302: Усны экологийн болон эдийн засгийн шинэчлэгдсэн үнэ. Pub. L. No. 302/2011, Монгол улс, (2011)
- IUCN 1994 – Guidelines for PA Management Categories.
- Жайка, Улаанбаатар хотын мастер төлөвлөгөө, хотын хөгжлийн судалгаа. Улаанбаатар хот, (2008)
- Д.Лхагвадорж, М.Хаук, Ц.Дуламсүрэн, Ж.Цогтбаатар, Эдийн засгийн өөрчлөлт, уур амьсгалын дулаарлын үеийн Монгол Алтайн нурууны ой хээрийн бүсийн нүүдлийн мал аж ахуй. Үржил шимгүй байгаль орчин сэтгүүл, 88, 82–89. doi:10.1016/j.jaridenv.2012.07.01, (2013)
- Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам. Усалгаатай газар тариалангийн жилийн тайлан. Улаанбаатар хот, (2013)
- Монголын ноос, ноолуурын холбоо, Тэмээний ноос. 2014 оны 8-р сарын 23, <http://english.mongoltextile.mn/nav/78>, (2013)
- Үндэсний Статистикийн Хороо, Газар тариалангийн улсын анхдугаар тооллого, 2011. Улаанбаатар хот. (2012)
- Үндэсний Статистикийн Хороо, Бүлэг 24. Байгаль орчин. Статистикийн эмхэтгэл 2012. Улаанбаатар хот: ҮСХ. (2013)
- Үндэсний Статистикийн Хороо, Статистикийн мэдээ /Салбараар/. 2014 оны 2-р сарын 20, www.1212.mn, (2014a)
- Үндэсний Статистикийн эмхэтгэл, Өрхийн сарын орлого. 2014 оны 5-р сарын 4, www.1212.mn, (2014b)
- Үндэсний Статистикийн Хороо, Бүлэг 18. Газар тариалан. Статистикийн эмхэтгэл 2013. Улаанбаатар хот: ҮСХ, (2014c)
- Үндэсний Статистикийн Хороо, ҮСХ-ноос СПАН төсөлд зориулан гаргаж өгсөн нийтлэгдээгүй мэдээлэл, Улаанбаатар хот, (2014d)
- Үндэсний Статистикийн Хороо, Малын тоо толгой, 2014 оны 8-р сарын 19 http://1212.mn/contents/stats/contents_stat_fld_tree_html.jsp, (2014e)
- Д.Одонцэцэг, К.Иханбай, Л.Жанчивдорж, С.Чулуунхуяг, Б.Баяржаргал, Х.Бадарч, Усны экологийн болон эдийн засгийн үнэ цэнэ. Улаанбаатар хот, (2010)



- Монгол улс: Хатуу ширүүн өвөл - Зуд (2010 оны 7-р сар). http://reliefweb.int/sites/reliefweb.int/files/resources/4E597847D9F7CD-5685257751007620DC-SS-2010-MNG_0623.pdf, (2010)
- К.Шагдарсүрэн, Мал аж ахуйн технологи (хуу. 133–137). Улаанбаатар хот, (2007)
- Өнөөдөр сонин. Их гүрний бодлого, түүхий эдийн бааз суурь. Өнөөдөрөдөр тутмын сонин, 18.10.2013. 20, 2014, from <http://www.mongolnews.mn/p/46742>, (2013)
- Тэрэлж зочид буудал: “2012 оны хамгийн тансаг зэрэглэлийн 50 зочид буудалд амрах нь,” 2011 оны 10-р сар; Time сэтгүүл, 2010 оны 4-р сар; Элит зочид буудал, 2010 оны 5,6-р сар; Конде Наст Аялагч сэтгүүл, 2008 оны 10-р сар.
- Туул голын сав газрын усны менежментийн төлөвлөгөө - ТГСГУМТ. Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яам /хуучнаар/ (2012)
- НҮБ-ын ДХБ-ын Тогтвортой аялал жуулчлал-Ядуурлыг бууруулах хөтөлбөр (2014)<http://www.unwtostep.org>
- НҮБХХ Зорилтот Салбарын Шинжилгээ (2013) http://www.undp.org/content/undp/en/home/librarypage/environment-energy/environmental_finance/targeted-scenario-analysis.html
- НҮБ-Усны сүлжээ.Монгол улс, (2013)
- НҮБХХ, 2011. Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн Гүрж улсын эдийн засаг хийгээд хүн амын аж амьдралд оруулж буй хувь нэмэр
- М.Зао, Г.Хан, Х.Мэй, БНХАУ-ын ӨМӨЗО-ы нөөц баялаг, өнөөгийн нөхцөл байдал. Газар тариалангийн факультет, Нийгата их сургууль, 58(2), 129-132.(2006)